

БҮЛЭГ II. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ОЛОН УЛСЫН СТАНДАРТЫН ТАНИЛЦУУЛГА

A. ҮНДСЭН ОЙЛГОЛТУУД

Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөл (НББОУСЗ) стандарт боловсруулдаг:

2000 онд бүтцийн өөрчлөлт хийгдэхээс өмнө НББОУС боловсруулах бүтэц нь НББОУСХороо (IAS) байсан юм. НББОУСХ 1973 оноос 2000 он хүртэл НББОУС боловсруулан гаргаж байлаа. 2000 онд НББОУСХ дахин зохион байгуулагдсанаар НББОУСХ-ны сан (НББОУСХС) бий болсон. Энэ санг итгэмжлэгдэгчид удирддаг бөгөөд ашгийн бус байгууллага юм. Үүрэг нь НББОУСЗ-ийг дэмжин, үйл ажиллагааг нь санхүүжүүлэх явдал. НББОУСЗ нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС) гэж нэрлэгдэх болсон стандарт боловсруулж, батлах үүрэгтэй.

НББОУСХС ба НББОУСЗ-ийн зорилго:

- Олон нийтийн эрх ашгийн тусын тулд НББ-ийн нэг багц стандарт бүрдүүлж, хэвлүүлэх, улмаар түүнийг дэлхий дахинаа хүлээн зөвшөөрүүлэх үйл явцыг дэмжин сайшаах.
- Эдгээр стандартыг ягштал мөрдөх явдлыг дэмжих.
- Үндэсний НББ-ийн стандартыг НББОУС-д ойртуулан нийцүүлэх.

Санхүүжилт:

НББОУСХС-г НББ-ийн мэргэжлийн байгууллага, компани, санхүүгийн байгууллага, НББ-ийн фирм, бусад байгууллагын үзүүлдэг санхүүгийн дэмжлэг, түүнчлэн НББОУС болон бусад хэвлэлийн борлуулалтын ашгаас санхүүжүүлдэг.

ХОЛБОО БАРИХ ХАЯГ:

Ажлын газар ба шуудангийн хаяг:

International Accounting Standards Board

30 Cannon Street

London EC4M 6XH

United Kingdom

Phone: +44 20 7246 6410

Website: www.iasb.org.uk

Нягтлан бодох бүртгэлийн олон улсын өөр нэг чухал байгууллага бол **Нягтлан бодогчдын олон улсын холбоо юм (НБОУХ)**.

НБОУХ бол аудит, бизнес, үйлдвэр, улсын сектор, боловсролын салбарт ажилладаг нягтлан бодогч, түүнчлэн мэргэжлийн байгууллагатай тогтмол холбоотой ажилладаг зарим мэргэшсэн бүлгийнхнийг төлөөлсөн үндэсний НББ-ийн мэргэжлийн байгууллагыг нэгтгэсэн байгууллага юм. Одоогоор энэ холбоонд 113 орны 155 мэргэжлийн байгууллага, тэдгээрт гишүүнчлэл бүхий 2 сая гаруй нягтлан бодогч гишүүнээр бүртгэгдээд байна. Монгол улс одоогоор тус байгууллагад гишүүнээр элсэх өргөдлөө өгөөд байгаа билээ.

НБОУХ-ны эрхэм зорилго бол мэргэжлийн байгууллагыг хөгжүүлэх, олон нийтийн ашиг сонирхолд нийцсэн өндөр чанартай үйлчилгээ үзүүлэх зорилгоор өөрийн боловсруулан гаргасан стандартыг дэлхий дахинд нэгдмэл мөрдүүлэх явдал юм. НБОУХ нь 6 гол чиглэлээр удирдамж гаргадаг:

- Аудит: НБОУХ-оос АОУС, тайлбар, хэлэлцэх баримтыг гаргадаг.
- Боловсрол: НБОУХ-оос нягтлан бодогчдод зориулсан Боловсролын олон улсын стандарт, удирдамж гаргадаг.
- Ёс зүй: НБОУХ-оос гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын дагаж мөрдөх ёс зүйн дүрэм нь дэлхий дахинд хүлээн зөвшөөрөгдсөн загвар болно.
- Санхүүгийн ба удирдлагын НББ: НБОУХ-оос Менежментийн НББ-ийн олон улсын практик тайлбар, судалгаа болон бусад материалыг хэвлэн гаргадаг.
- Мэдээллийн технологи: Мэдээллийн технологийн төслийг хянаж үзэхэд удирдлага, нягтлан бодогчдод туслах үүднээс удирдамж гаргадаг.
- Улсын секторын НББ: НБОУХ-оос улсын секторын НББ-ийн олон улсын стандарт (УСНББОУС), удирдамж, судалгааны материал гаргадаг.

НБОУХ-ны англи хэл дээрх төрөл бүрийн хэвлэлүүдийг уг холбооны вэбсайтаас үнэ төлбөргүй авч ашиглаж болно: www.ifac.org.

САНХҮҮЖИЛТ: НБОУХ-ны санхүүжилт юуны өмнө гишүүн орнуудын татвараас бүрддэг.

ХОЛБОО БАРИХ ХАЯГ:

Ерөнхий магадлах зүйл гарвал: Maria Hermann
IFAC
535 Fifth Avenue, 26th Floor
New York, NY 10017
USA
Phone: 1-212-286-9344 Ext.112
Fax: 1-212-286-9570
E-mail: mariahermann@ifac.org

Хэвлэл, зохиогчийн эрхтэй холбоотой мэдээллийг:

Damarys Gil
Phone: 1-212-286-9344 Ext.103
E-mail: damarysgil@ifac.org

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ОЛОН УЛСЫН СТАНДАРТ

СТОУС-ын өмнөх уг

Санхүүгийн тайланг бэлтгэх, толилуулах цар хүрээ

- НББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга
 НББОУС 2 Бараа материал
 НББОУС 7 Мөнгөн гүйлгээний тайлан
 НББОУС 8 Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал, суурь алдаа ба НББ-ийн бодлогын өөрчлөлт
 НББОУС 10 Балансын дараахь үйл явдал ба болзошгүй зүйл
 НББОУС 11 Барилгын гэрээ
 НББОУС 12 Орлогын албан татвар
 НББОУС 14 Санхүүгийн мэдээллийг сегментээр тайлагнах нь
 НББОУС 15 Үнийн өөрчлөлтийн нөлөөг тусгасан мэдээлэл
 НББОУС 16 Үндсэн хөрөнгө (өмч, барилга, тоног төхөөрөмж)
 НББОУС 17 Түрээсийн бүртгэл
 НББОУС 18 Орлого
 НББОУС 19 Ажиллагсдын тэтгэвэр, тэтгэмж
 НББОУС 20 ЗГ-ын буцалтгүй тусламжийн бүртгэл, ЗГ-ын тусламжийн тодруулга
 НББОУС 21 Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн нөлөө
 НББОУС 22 Бизнесийн нэгдэл
 НББОУС 23 Зээллэгийн зардал
 НББОУС 24 Холбоотой талуудын тодруулга
 НББОУС 25 Хөрөнгө оруулалтын НББ
 НББОУС 26 Тэтгэвэр тэтгэмжийн төлөвлөгөөг бүртгэж, тайлагнах нь
 НББОУС 27 Санхүүгийн нэгдсэн тайлан ба охин компани дахь хөрөнгө оруулалтын бүртгэл
 НББОУС 28 Холбоотой талуудад оруулсан хөрөнгө оруулалтын бүртгэл
 НББОУС 29 Ханшны хэт уналттай эдийн засаг дахь санхүүгийн тайлагнал
 НББОУС 30 Банк, түүнтэй адилтгах санхүүгийн байгууллагын санхүүгийн тайлагналын нэмэлт тодруулга
 НББОУС 31 Хамтарсан үйлдвэрийн хувь оролцооны санхүүгийн тайлагнал
 НББОУС 32 Санхүүгийн хэрэглүүр: Нэмэлт тодруулга ба толилуулга
 НББОУС 33 Нэгж хувьцааны ногдол ашиг
 НББОУС 34 Завсар хугацааны санхүүгийн тайлагнал (1999-1-1-ээс мөрдсөн)
 НББОУС 35 Зогсоосон үйл ажиллагаа
 НББОУС 36 Хөрөнгийн бууралт (муудалт)
 НББОУС 37 Нөөц, Болзошгүй өр төлбөр ба болзошгүй хөрөнгө
 НББОУС 38 Биет бус хөрөнгө
 НББОУС 39 Санхүүгийн хэрэглүүр: Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт
 НББОУС 40 Хөрөнгө оруулалтаарх өмч
 НББОУС 41 Хөдөө аж ахуйн бүртгэл

Стандартын мөн чанарыг илүү үнэн зөвөөр илэрхийлэхийн тулд НББОУС3-өөс батлан гаргасан НББОУС-ыг СТОУС гэж нэрлэхээр болж байна (2000 оноос хойш). Гэхдээ дээр дурдсан стандартуудыг НББОУС гэсэн хуучин нэрээр нь үргэлжлүүлэн нэрлэх болно.

САНХҮҮГИЙН ТАЙЛАН БЭЛТГЭЖ, ТОЛИЛУУЛАХ ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Санхүүгийн тайлан бэлтгэж толилуулах үзэл баримтлалд санхүүгийн тайланг хэрхэн бэлтгэж, хэрэглэгчдэд толилуулах үндсийг бүрдүүлэх концепц буюу үзэл санааг тодорхойлсон байдаг. Энэ бол яг стандарт биш, харин НББОУСЗ, үндэсний НББ-ийн стандарт боловсрууллагч байгууллага, тайлан бэлтгэгч, аудитор, санхүүгийн тайлан хэрэглэгчдэд зориулсан удирдамж болж ашиглагддаг юм.

Энэ цар хүрээ дараахь зүйлсийг тусгасан:

- ◆ **Санхүүгийн тайлангийн зорилго;**
- ◆ **НББ, санхүүгийн тайлангийн зарчим;**
- ◆ **Санхүүгийн тайлангийн элементүүдийн тодорхойлолт, хүлээн зөвшөөрөлт, хэмжилт.**

Санхүүгийн тайлан нь санхүүгийн тайлагналын нэг хэсэг бөгөөд уг тайлантай хамт уншигдах тэмдэглэл, хуваарь, тодруулгыг мөн багтаасан байна.

Энэ цар хүрээг бизнесийн бүх байгууллага (улсын болон хувийн сектор) санхүүгийн тайлан бэлтгэн гаргах үедээ дагаж мөрднө.

Уг цар хүрээнд санхүүгийн тайлан бэлтгэх, толилуулах эн тэргүүний хариуцлагыг тухайн байгууллагын удирдлага хүлээнэ гэдгийг зориуд анхааруулсан байдаг.

Санхүүгийн тайлангийн зорилго

Санхүүгийн тайлангийн зорилго бол байгууллагын санхүүгийн байдал, гүйцэтгэл, мөнгөн гүйлгээний талаарх мэдээллээр янз бүрийн хэрэглэгчдийг хангаж, тэдэнд эдийн засгийн шийдвэр гаргахад нь тус дөхөм үзүүлэх явдал юм.

Санхүүгийн тайлангийн мэдээллийг хэрэглэгчид уг мэдээлэлд холбогдолтой тодорхой зарим шинж чанар, хязгаарлалтын талаар мэдэж байх ёстой.

Санхүүгийн тайлан нь:

- **Ажил гүйлгээг санхүүгийн тоогоор илэрхийлэх**—Санхүүгийн тайлан дахь мэдээлэл нь худалдан авах чадвараас үл хамааран ихэвчлэн мөнгөний нэгжээр илэрхийлэгдсэн байдаг.
- **Тооцоолол, шийдлийг тусгах**—НББ-ийн мэдээлэл бол яг жинхэнэ мэдээлэл биш юм. Энэ нь мэргэжлийн шийдэл дээр үндэслэдэг.
- **Мөн чанарын хувьд түүхэн үйл явцыг тусгасан байдаг**—Санхүүгийн тайлан нь өнөөгийн болон ирээдүйн төлөв байдлын талаарх мэдээллийг агуулахаас илүү өнгөрсөн ажил гүйлгээг тусгасан байдаг.
- **Зорилгын хувьд ерөнхий байдаг**—Санхүүгийн тайлан нь янз бүрийн хэрэглэгчдэд зориулан бэлтгэгдсэн байдаг тул төрөлжсөн буюу онцгой зорилгод шаардагдах гүнзгий мэдээлэл агуулдаггүй.
- **Зардал гаргадаг** —Зардлыг санхүүгийн тайлангийн бэлтгэл, ашиглалтад багтаадаг. Тэдгээр тайланг бэлтгэж, ашиглаж байгааг зөвтгөхийн тулд өгөөж нь зардлаас илүү гарсан байх ёстой. Бүх зардал болон өгөөжийг шууд тооцох аргагүй байдаг.

Үндсэн төсөөлөл: Санхүүгийн тайлангууд нь дараахь таамаглал буюу зарчим дээр дээр үндэслэгддэг:

- **Аккруэл суурь(Accrual basis)** – НББ-ийн акрюль суурийг ашиглана. Ажил гүйлгээг гарсан үед нь хүлээн зөвшөөрч, холбогдох хугацаанд нь бүртгэдэг.
- **Тасралтгүй зарчим(Going concern)** – НББ-ийн зорилгоор байгууллага бизнесийн үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлнэ гэж таамаглах ёстой. Өөрөөр хэлбэл ойрын ирээдүйд татан буугдахгүй гэсэн үг. Энэ төсөөлөл нь санхүүгийн бүртгэлд хэрэглэж байгаа ангилал, хэмжилтийн шалтгааныг бий болгодог. (жишээлбэл, хөрөнгө өртөлбөрийг урт ба богино хугацаагаар ангилах, хөрөнгийг түүхэн өртгөөр нь бүртгэх гэх мэт)

Санхүүгийн тайлан дахь мэдээллийг хэрэглэгчдэд илүү ашигтай болгохын тулд цар хүрээнд хэд хэдэн чанарын шинж төлөвийг тодорхойлж өгсөн:

- **Ойлгомжтой байдал(Understandability)** — Харицангуй мэдээлэл сайтай хэрэглэгчдэд ойлгомжтой байхууцаар мэдээллийг танилцуулах ёстой.
- **Тохиромжтой буюу хамаатай байх(Relevance)**—Хамаатай байх гэдэг нь өнгөрсөн, одоо ба ирээдүйн үйл явдалд үнэлгээ өгөх, урьд нь өгсөн үнэлгээ, хийсэн тооцооллоо бататгах эсвэл засахад нь туслах замаар мэдээллийг хэрэглэгчийн шийдвэр гаргалтлантанд нөлөөлж чадаж байгаа чанар юм.
 - **Материаллаг байх (Materiality)** гэдэг нь хамаатай байх шинжийн нэг бүрэлдэхүүн хэсэг юм. НББОУС нь зөвхөн материаллыг зүйлийн хувьд хэрэглэгддэг. Материаллаг байдлыг авч үзсэн тусдаа стандарт байдгүй. Орхигдсон болон буруу тайлагнагдсан мэдээлэл нь санхүүгийн тайландаа үндэслэн гаргасан эдийн засийн шийдвэрт нөлөөлж байвал тухайн мэдээллийг материаллаг гэж үзнэ. Материаллаг байдал нь зөвхөн тухайн зүйлийн хэмжээ бус түүний мөн чанараас хамаардаг.
 - **Цаг хугацаандаа байх (Timeliness)** гэдэг нь тохиромжтой, хамаатай байх шинжийн бүрэлдэхүүн хэсэг юм. Хэрэв мэдээлэл хэрэглэгчдэд цаг хугацаандаа очиж байвал ашигтай байж чадна. Энэ нь бүх асуудлыг мэдэхээс өмнө мэдээллийг тайлагнаж болно гэсэн санааг илтгэж болох юм. Мэдээлэл цаг хугацаандаа байх чанарыг найдвартай байх шинж чанартай тэнцвэржүүлж хэрэглэх ёстой.
- **Найдвартай байх(Reliability)**-Найдвартай байхын тулд мэдээлэл дараахь чанарыг агуулсан байх ёстой:
 - **Хянагдсан буюу шалгагдсан байх(Verifiability)**—Мэдээлэл нь үндсэн нотолгоонд тулгуурласан байх ёстой.
 - **Төв голч чанартай байх(Neutrality)**—Мэдээлэл нь аливаа туйлширлаас ангид байх ёстой. Мэдээлэл нь урьдчилж ямарваа тодорхойлсон үр дүн эсвэл үзэл санаа руу туйлшран хандсан байх ёсгүй0
 - **Толилуулгын шударга байдал(Representational faithfulness)**—Мэдээлэл нь ажил гүйлгээ, эдийн засгийн үйл явдлыг үнэн шударгаар илэрхийлсэн байх ёстой.
 - Ажил гүйлгээг үнэн шударгаар илэрхийлэхийн тулд зөвхөн тэдгээрийн хуульд заасан хэлбэрийг бус мөн бодит шинжийг нь тооцож үзэх хэрэгтэй. **Мөн чанарыг хэлбэрээс илүүд үзнэ (Substance over form)** гэсэн зарчим бол санхүүгийн тайлагналын чухал гол зарчим юм.
 - Тооцоолол ашигладаг мөн тодорхой бус байдал оршдог нь найдвартай байх шинжид нөлөөлдөг. Ийм тодорхой бус байдлын зарим хэсгийг нэмэлт тодруулга хийх замаар, мөн санхүүгийн тайланг бэлтгэхдээ **Хянамгай байх (Prudence)** зарчмыг мөрдсөнөөр зохицуулдаг. Хянамгай байх гэдэг нь хөрөнгө буюу орлогыг илүү тайлагнахгүй, өр төлбөр ба зардлыг дутуу тайлагнахгүй байхын тулд шийдэл гүйцэтгэх үедээ анхаарал болгоомжтой байхыг хэлнэ. Үүнийг **Консерватизмын зарчим (Conservatism)** ч гэж нэрлэдэг.

- **Иж бүрэн байдал(Completeness)**—Санхүүгийн тайлан дахь мэдээлэл найдвартай байхын тулд материаллаг байдал, зардлын хүрээндээ иж бүрэн байх ёстай.
- **Зэрэгцүүлэгдэх чадвар(Comparability)**—Аливаа мэдээллийг тодорхой хугацааны дотор адил төстэй бусад мэдээллэлтэй зэрэгцүүлэгдэхүйц байдлаар толилуулах ёстай. Түүнчлэн мэдээллийг бусад аж ахуйн нэгжийн мэдээллэлтэй зэрэгцүүлэгдэх боломжтой байхаар бэлтгэх ёстай. Тууштай байх зарчим бол зэрэгцүүлэгдэхүйц байдлын чухал элемент мён.
- **Тууштай байх(Consistency)**—Нэг тайлант үеэс нөгөө тайлант үед мэдээллийг нэг ижил аргаар толилуулах ёстай. Өөрөөр хэлбэл хэмжих, тайлагнахад нэг л аргыг ашиглах ёстай. Хэрэв эдгээр аргаа өөрчилсөн бол тэр тухай нэмж тодруулах ёстай.

Ойлгомжтой, хамаатай, найдвартай, зэрэгцүүлэгдэхүйц мэдээллээр хангахын тулд нягтлан бодогч дээр дурдсан үндсэн төсөөллөөс (аккруэл суурь ба тасралтгүй зарчим)-аас гадна хэд хэдэн нэмэлт төсөөллийг хэрэглэх хэрэгтэй. Эдгээр төсөөллийг дараах зүйлийг агуулсан санхүүгийн мэдээллээс харж болно:

- **Аж ахуйн нэгж бие даасан байх(Separate entity)**—Аж ахуйн үйл ажиллагаа нь тодорхой нэг аж ахуйн нэгжтэй холбоотой гардаг. Энэ нь бизнес, бизнесийн сегмент эсвэл нэгдсэн бүлэг байж болох юм. Иймээс бизнесийн нэгжийн үйл ажиллагааг түүний эздээс эсвэл бусад бизнесийн нэгжээс анхааралтайгаар зааглан үзэх хэрэгтэй. (Жич: байгууллагын нэр санхүүгийн тайлангийн хамгийн дээд хэсэгт бичигдэх ёстай.)
- **Хэмжих нэгж(Unit of measure)**—НББ-д санхүүгийн мэдээллийг үндэсний мөнгөн нэгжээр илэрхийлэх ёстай (Монгол улсад энэ нь төгрөг байна.)
- **Цаг хугацаа(Time period)** — Байгууллагын аж ахуйн үйл ажиллагаа нь түүний оршин тогтоно хугацаанаас богино байх хугацааны туршид тайлагнагдаж болох юм. Практикт тайлагнах хугацаа өөр өөр байж болох ч хамгийн нийтлэг хугацаа бол нэг жил, ялангуяа календарийн нэг жилийн хугацаа байдаг. Тайлагнаж байгаа хугацааг санхүүгийн тайлангийн дээд хэсэгт бичдэг.

Үйл ажиллагааны хугацаанд нягтлан бодогч хөрөнгө ба өр төлбөр, орлого ба зардлыг хүлээн зөвшөөрөх, тайлагнахтай холбоотой тодорхой зарчмыг баримтлах ёстай. **Хэрэгжилтийн 4 үндсэн** зарчим байдаг::

- ◆ **Өртгийн зарчим(Cost principle)**—Худалдан авах үе (түүхэн өртөг)-ийн өртөг (өгсөн мөнгөтэй адилтгах зүйл) нь уг зүйлийг санхүүгийн тайланд эхлэн бүртгэх тохиromжтой суурь болдог. Өртгийн зарчим нь бизнесийн холбогдолгүй талын ажил гүйлгээг илэрхийлнэ.
- ◆ **Орлогын зарчим (Orlogын хэмжилтийг оруулна) (Revenue principle)** — Орлогын хугацаа болон дүнг нь тодорхойлох боломжтой бол орлогыг олсон үед нь хүлээн зөвшөөрч санхүүгийн тайланд бүртгэнэ. Эзэмшлийг шилжүүлсэн, үйлчилгээг үзүүлсэн үед орлого олсон гэж тооцно. Орлогыг хүлээн авсан буюу авахаар тооцсон мөнгө, түүнтэй адилтгах зүйлээр хэмжинэ. НББ-ийн аккруэл суурь ашиглахыг орлогын зарчим шаарддаг.
- ◆ **Зохицох зарчим(Matching principle)** —Орлого олох зорилгоор гаргасан зардал буюу өртгийг орлогыг хүлээн зөвшөөрсөн тайлант үед мөн хүлээн зөвшөөрч бүртгэнэ (орлого, зардал хоорондоо зохицож байх ёстай). Орлого, зардлын хоорондхи холбоог маш тодорхой харуулах боломжгүй тохиолдолд зардлыг хэд хэдэн тайлант хугацаанд системтэй, зохистой суурьт үндэслэн хуваарилах ёстай. НББ-ийн аккруэл суурь ашиглахыг зохицох зарчим шаарддаг.
- ◆ **Бүрэн нэмэлт тодруулгын зарчим (Full-Disclosure Principle)** —Санхүүгийн тайлан хэрэглэгчдийг эдийн засгийн шийдвэр гаргахад шаардагдах эдийн засгийн бүх хамаатай мэдээллийг байгууллагын санхүүгийн тайланд нэмж

тодруулах ёстой. Зарим мэдээллийг санхүүгийн тайлангийн нүүрэн хэсэгт, заримыг нь Тэмдэглэл ба Тайлбар гэсэн хэсэгт багтаадаг.

ДАСГАЛ 1 - НББ-ийн зарчмууд

Дор дурдсан нөхцөл тус бүрийн хувьд хамаарах НББ-ийн зарчмуудыг олж тэмдэглэнэ үү!

- а) Цаг хугацаандаа байх
- б) Тууштай байх
- в) Бүрэн нэмэлт тодруулга
- г) Консерватизм/хянамгай байх
- д) Өртгийн зарчим
- е) Материаллаг байх

Зарим нөхцөлийн хувьд нэгээс олон зарчмыг дурьдаж болох тул тохирох бүх хариуг бичнэ үү. (а,б гэх мэтээр)

- | | |
|-------|---|
| 1 | Жижиг мөнгөн сангаас хийгдэх бүх төлбөрийг Бусад зардлын Дт-д бичнэ. |
| <hr/> | |
| 2 | Балансын огноо өдөр компанийн санхүүгийн тайланд албан ёсоор өр төлбөр гэж бүртгэгдээгүй боловч уг компанийтай холбоотой шүүхийн шийдвэрээр үүсч болзошгүй өр төлбөрийн талаарх тайлбарыг санхүүгийн тайланд оруулдаг |
| <hr/> | |
| 3 | Урт хугацаат хөрөнгө оруулалтыг түүхэн өргөөр бүртгэнэ. |
| <hr/> | |
| 4 | Жижиглэнгийн дэлгүүр сар бүрийн санхүүгийн тайлан гаргах зорилгоор бараа материалын бүрэн тооллогоос өөр тооцоолол ашигладаг. |
| <hr/> | |
| 5 | Бараа материалыг өртөг зах зээлийн аль багаар буюу цэвэр боломжит үнэ цэнээр бүртгэнэ. |
| 6 | 2000 ба 2001 онд бараа материалын бүртгэлийн адил арга ашиглана |
| <hr/> | |
| 7 | Томоохон үйлдвэрлэгч компанид ашиглагддаг үнэ цэнэ багатай сэлбэг хэрэгслийг худалдан авах үед нь зардал гэж бүртгэдэг. |

Үзэл баримтлал нь санхүүгийн тайлангийн **элементүүд**, болон **хэмжих** болон **хүлээн зөвшөөрөх** шалгуурыг тодорхойлсон байдаг.

Санхүүгийн тайлан нь ажил гүйлгээ, бусад үйл явдлын санхүүгийн нөлөөг тэдгээрийг эдийн засгийн шинж чанараар нь үнддсэн ангилалд ангилж бүлэглэх замаар харуулдаг. Эдгээр үндсэн ангиллыг санхүүгийн тайлангийн элементүүд гэж нэрлэдэг.

Санхүүгийн байдал (Баланс)-ын хэмжилттэй шууд холбоотой элементүүд нь:

Хөрөнгө
Өр төлбөр
Эзэмшигчдийн өмч

Хөрөнгө—Өнгөрсөн ажил гүйлгээний үр дүнд хүлээн авсан бөгөөд түүнээс ирээдүйн эдийн засгийн үр өгөөж хүртэхээр хүлээгдэж байгаа, аж ахуйн нэгжийн хяналтад буй эдийн засгийн нөөц юм. Үндсэн ойлголтууд нь:

- Ирээдүйн эдийн засгийн үр өгөөж
- хяналт
- өнгөрсөн ажил гүйлгээ

Хөрөнгө гэж ангилагдахын тулд зүйл нь **хөрөнгийн тодорхойлолт** болон **хүлээн зөвшөөрөх** шалгуурын аль алийг хангаж байх ёстай.

Өр төлбөр— Ирээдүйд эдийн засгийн үр өгөөжөө золиослоход (хөрөнгөө шилжүүлэх буюу ашиглах, ирээдүйд үзүүлэх үйлчилгээ) хүргэх магадлалтай бөгөөд өнгөрсөн ажил гүйлгээнээс үүссэн байгууллагын хүлээх хариуцлага юм. Үндсэн концепц (үзэл санаа) нь:

- ирээдүйн эдийн засгийн золиос
- үүрэг хариуцлага
- өнгөрсөн ажил гүйлгээ

Өр төлбөр гэж ангилагдахын тулд өр **төлбөрийн тодорхойлолт** болон **хүлээн зөвшөөрөх шалгуурын** аль алийг хангасан байх ёстай.

Эздийн өмч— Аж ахуйн нэгж бүх өр төлбөрөө барагдуулсны дараа үлдэж байгаа хөрөнгө дахь үлдэх сонирхол юм.

Балансын үндсэн тэнцэл нь:

$$\text{Хөрөнгө} = \text{Өр төлбөр} + \text{Эздийн өмч}$$

Алгебрийн аргаар буцаан тооцож үзвэл, энэ тэнцэл:

$$\text{Хөрөнгө} - \text{Өр төлбөр} = \text{Эздийн өмч}$$

Энэ бол эздийн өмчийн тодорхойлолт бөгөөд Цэвэр хөрөнгө гэж бас нэрлэдэг.

Гүйцэтгэлийн хэмжилт (Орлогын тайлан)-тэй шууд холбоотой элементүүд нь:

Орлого (Олзыг оролцуулна)
Зардал (гарзыг оролцуулна)

Орлого—Тайлант хугацаанд эздийн нийлүүлсэн хувь оролцооноос бусад шалтгааны улмаас хөрөнгийг өсгөж, өр төлбөрийг багасгах дотогш урсгал буюу хөрөнгийн өсөлт хэлбэрээр бий болсон эдийн засгийн өгөөжийн өсөлт юм. Үүнд:

- **Орлого** аж ахуйн нэгжийн гол үйл ажиллагааг бүрдүүлдэг бараа, үйлчилгээний борлуулалт болон бусад үйл ажиллагаагаа
- **Олз** аж ахуйн нэгжийн үндсэн үйл ажиллагааны хавсарга маягаар явуулсан ажил гүйлгээнээс үүссэн дотогш урсгал

Зардал— Тайлант хугацаанд эздэд хуваарилсанаас бусад шалтгааны улмаас гадагш урсгал хэлбэрээр хөрөнгийг бууруулж, өр төлбөрийг ихэсгэдэг эдийн засгийн өгөөжийн бууралт юм. Үүнд:

- **Зардал** аж ахуйн нэгжийн гол үйл ажиллагааг бүрдүүлдэг бараа, үйлчилгээний гадагш чиглэсэн үйл ажиллагаагаа
- **Гарз** аж ахуйн нэгжийн үндсэн үйл ажиллагааны хавсарга маягаар явуулсан ажил гүйлгээнээс үүссэн гадагш урсгал

Хүлээн зөвшөөрөлт—Санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөгдөх элементийн тодорхойлолтыг хангаж байгаа зүйлийн хувьд хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг мөн хангах ёстой:

- Тухайн зүйлтэй холбоотойгоор эдийн засгийн ирээдүйн үр өгөөж байгууллага руу дотогш урсах эсвэл түүнээс гадагш гарах магадлалтай;
- Тухайн зүйлийн өртөг буюу үнийг найдвартай хэмжих боломжтой.

Санхүүгийн тайлангийн элементийн **хэмжилтэд** хэмжилтийн үндсийг сонгох үйл явц орно:

- Түүхэн өртөг—хамгийн түгээмэл ашиглагддаг үндэс буюу суурь. Үүнийг ихэнхдээ хэмжилтийн бусад суурьтай хослуулдаг. (жишээ нь, бараа материалыг балансад өртөг, зах зээлийн аль багаар нь эсвэл цэвэр боломжит үнэ цэнээр бүртгэдэг.)
- Одоогийн өртөг
- Цэвэр боломжит үнэ цэнэ
- Өнөөгийн үнэ цэнэ

Кэйс жишээ

Нягтлан бодох бүртгэлийн онолын ойлголт ба зарчим

Зааварчилгаа:

Доор өгүүлэх тохиолдлуудын аль алины хувьд дараахь асуултад хариулна уу:

- Хэнийх нь зөв бэ, нягтлан бодогч А юу, эсвэл нягтлан бодогч Б юу?
- 1-р асуултад хариулахын тулд та өөрөө НББ-ийн ямар гол концепц буюу зарчмыг харгалзаж үзсэн бэ?

1-р тохиолдол

Монгол тавилга компанийд үйлчлүүлэгчдэдээ тавилгыг нь хүргэж өгөх ачааны машин хэрэгтэй болов. Ингээд Улаанбаатар Трак компаниас ачааны машин худалдаж авахаар төлбөрийн нөхцлийг заасан гэрээнд гарын үсэг зурав. Уг гэрээнд ачааны машины үнийг Улаанбаатар трак компанийд нийт 36 сарын хугацаанд сар бүрээр хэсэгчлэн төлөхөөр тохиролцсон байна. Дурдсан хугацааны эцэст ачааны машин Монгол тавилга компаний эзэмшилд очих юм. Энэ гэрээ нь "Түрээсийн гэрээ" гэсэн нэртэй байв. Монгол тавилга компаний нягтлан бодогч А уг машиныг хөрөнгө (тоног төхөөрөмж) гэж бүртгээд харин өр төлбөрийн хэсэгт түүний нийт үнийн дүнгээр УБ трак компанийд өгөх өглөгөөр бүртгэх ёстой гэж үзсэн. Харин нягтлан бодогч Б нь Монгол тавилга компани ачааны машиныг хөрөнгө гэж бүртгэхг ёсгүй ба гэрээ нь нэгэнт түрээсийн гэрээ гэсэн нэртэй тул түрээсийн зардлаа сар бүр бүртгэх ёстой гэж үзэж байна.

Тохиолдол 2

Good Times сонины газар өөрсдийнх нь боловсруулсан зар сурталчилгааны дизайныг өрсөлдөгч компани нь өөрийн сурталчилгаанд хууль бусаар ашиглаж байгааг мэдээд шүүхэд хандсан байна. Good Times сонины газрын өмгөөлөгчийн үзэж байгаагаар Good Times шүүх хуралдаанд ялах бөгөөд өрсөлдөгч компаниар 50 сая төгрөгийн хохирол нөхөн төлүүлнэ гэж тооцоолжээ. Гэхдээ энэ хэргийг шүүхээр шийдвэрлэхэд хамгийн наад зах нь 12 сар шаардана. Нягтлан бодогч А өөрийн өмгөөлөгчийн хамгийн сайн тооцоололд үндэслэн компанийн орлого 50 сая төгрөгөөр нэмэгдэнэ гэж үзэж байна. Харин энэ хэргийн эцсийн үр дүн тодорхой бус байгаа тул орлогоо нэмэгдэнэ гэж үзэж болохгүй гэсэн санааг нягтлан бодогч Б баримталж байна.

Тохиолдол 3

MN арилжааны банк нэг үйлчлүүлэгчдээ жилийн 24 хувийн хүүтэй зээл олгосон. Хүүгийн төлбөрийг сар бүр, харин үндсэн зээлээ 12 сарын дараа буцаан төлнө. Энэ үйлчлүүлэгч 3 сарын хугацаанд хотод байхгүй тул эхний 3 сарын хүүгээ явахаасаа өмнө урьдчилан төлөхөөр шийдсэн. Ингээд тэр эхний 3 сарын хүүгийн төлбөр болох 60,000 төгрөгийг зээл авсан өдрөө банкинд төлөв. Банкны нягтлан бодогч А-ийн үзэж байгаагаар банк нэгэнт хүүгээ хараахан ногдуулаагүй тул 60,000 төгрөгийг өр төлбөр гэж бүртгэнэ. Харин банк зээлдүүлэгчээс хүүгийн орлого хүлээн авсан өдрөөр 60,000 төгрөгийг орлого гэж бүртгэнэ гэж нягтлан бодогч Б үзэж байна.

Тохиолдол 4

Magic Flowers компанийн нэг сарын борлуулалтын дундаж хэмжээ 2,500,000 төгрөг, сарын дундаж цэвэр орлого 500,000 төгрөг. Энэ компани башир цэцэг ургуулж, түүнийгээ борлуулах талаар мэргэжсэн компани юм. Цэцэг гоёлын цаасанд боогоод резинээр ороодог. Magic Flower компанийн худалдан авалтын хэлтэс тус бүр нь 5 төгрөгийн үнэтэй 20,000 ш резинэн боолт захиалдаг. Энэ нь түүний 6 сарын хэрэгцээг хангах тоо юм. Нягтлан бодогч А энэ резинэн боолтыг хөрөнгө гэж бүртгээд тэдгээрийг ашиглахаар тооцсон 6 сарын хугацаанд элэгдүүлнэ гэж үзсэн. Харин нягтлан бодогч Б уг резинэн боолтыг хөрөнгө биш зардал гэж бүртгэх бодолтой байна.

Б. САНХҮҮГИЙН ТАЙЛАН

НББОУС 1: Санхүүгийн тайлангийн толилуулгад санхүүгийн тайлангийн ерөнхий дөрвөн зорилгыг тодорхойлсон байдаг. Үүнд:

- **Баланс**
- **Орлогын тайлан**
- **Өмчийн өөрчлөлтийн тайлан**
- **Мөнгөн гүйлгээний тайлан**
- Санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг нь **Нягтлан бodoх бүртгэлийн бодлого болон тайлбар тэмдэглэл** бөгөөд үүнийг **Санхүүгийн тайлангийн тодруулга** гэж нэрлэн санхүүгийн тайлангийн ард хавсаргах ёстай.

Санхүүгийн тайлангийн таван элемент болох: **Хөрөнгө, Өр төлбөр, Эзэмшигчийн өмч, Орлого** болон **Зардлыг** дараах тэнцэтгэлийн аргыг ашиглан тусгана:

Балансад:

$$\text{Хөрөнгө} = \text{Өр төлбөр} + \text{Эздийн өмч}$$

Орлогын тайланд:

$$\text{Орлого} - \text{Зардал} = \text{Цэвэр ашиг буюу алдагдал}$$

Эдгээр нь НББОУС-ын санхүүгийн нягтлан бodoх бүртгэлд мөрдөгддөг үндсэн тэнцэтгэлүүд юм.

НББОУС 1-д тус стандартыг мөрдөн, санхүүгийн тайланд зохих тодруулга хийснээр тухайн компанийн санхүүгийн байдал, гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг **үнэн зөв илэрхийлнэ** гэж заасан байдаг.

Нягтлан бodoх бүртгэлийн бодлого (зүйл 20-22)-д компанийн удирдлага нь санхүүгийн тайланд тусгасан мэдээлэл **тохиromжтой буюу хамаатай байх**, мөн **найдвартай** болохыг бататгахын бодлого боловсруулах нь удирдлагын үүрэг хариуцлага гэж заасан байдаг.

Нягтлан бodoх бүртгэлийн олон улсын стандартад дэлгэрэнгүй тусгагдсан Санхүүгийн тайлантай холбоотой ихэнх дүрэм горимыг 1999 онд Сангийн Яамнаас баталсан санхүүгийн тайлан бэлтгэх болон толилуулах арга зүйд тусгажээ. 1-р хэсгийн 7-р зүйлд санхүүгийн тайлан бэлтгэх зарчмуудыг тодорхойлсон. Үүнээс vii зарчимд **хөрөнгө, өр төлбөрийг хооронд нь суутгахыг зөвшөөрөхгүй** гэж заажээ. НББОУС 1-ийн 33-37 зүйлд санхүүгийн тайлангийн элементүүдийг харилцан суутгахыг хориглох тухай болон орлого зардлын үзүүлэлтүүдийг хооронд нь суутган цэвэрлэж болох цөөн тооны тохиолдлыг заасан байдаг.

Ойлгомжтой байлгах зорилгоор баланс болон орлогын тайлангийн үзүүлэлтүүдийг ижил шинж чанарыг нь үндэслэн бүлэглэдэг. **Хөрөнгийг хөрвөх чадварын буурах дарааллаар, өр төлбөрийг барагдах хугацааны өсөх дарааллаар бүлэглэдэг.** Харин эздийн өмчийг байнга орших чадвар нь буурах дарааллаар бүлэглэдэг. НББОУС-д санхүүгийн тайлангийн мэдээллийг толилуулах болон ангилах зарим аргыг тодорхойлсон байдаг боловч тус стандарт нь төрөл бүрийн компанийд ижил төрлийн мэдээллийг өөр өөр аргаар харуулах боломж олгох зорилгоор уян хатан байдаг. Гэхдээ НББОУС-ын санхүүгийн тайлан бэлтгэх болон тодруулга хийх шаардлагууд болон үзэл баримтлалыг мөрдсөн тохиолдолд хэрэглэгчид төрөл бүрийн компанийн санхүүгийн тайланг харьцуулж чадна. Ангилал (булэглэх) нь тухайн салбарын онцлогоос хамаарч өөр өөр байна. Жишээ нь: банкны санхүүгийн тайлангийн ангилал. Банкны баланс,

орлогын тайлан нь үйлдвэр болон үйлчилгээний байгууллагынхаас өөр байдаг. Гэхдээ ижил талууд байдаг бөгөөд нягтлан бодох бүртгэлийн үндсэн тэнцэтгэлүүдийг аль ч тохиолдолд мөрдөх ёстай.

Энэ сэдвийн хүрээнд жишээ болгож “Солонго” компанийн Баланс, Орлогын тайлан, Мөнгөн гүйлгээний тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлан, Санхүүгийн тайлангийн тодруулгыг энд танилцуулж байна. Монголын нягтлан бодох бүртгэлийг сайжруулахаар Азийн Хөгжлийн Банкнаас өмнө хэрэгжүүлсэн төслийн хүрээнд Солонго компанийн санхүүгийн тайлагналыг НББОУС-ын стандартын дагуу хөрвүүлж, эдгээр тайланг бэлтгэсэн юм.

Баланс

Баланс нь тухайн компанийн тодорхой хугацааны санхүүгийн байдлыг илтгэдэг учраас санхүүгийн байдлын тайлан гэж нэрлэдэг. Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлангийн хэлбэр, бүрэлдэхүүн хэсгүүдийг толилуулах арга, нэмэлт мэдээлэлд хийх шаардлагатай тодруулгуудын талаар Санхүүгийн тайланг бэлтгэх болон толилуулах арга зүйд тусгасан (Сангийн яамны 1999 оны 215 тоот тушаалыг хавсаргав).

Баланс нь НББ-ийн хамгийн эхний тэнцэтгэлийг харуулдаг:

$$\text{ХӨРӨНГӨ} = \text{ӨР ТӨЛБӨР} + \text{ЭЗДИЙН ӨМЧ}$$

Санхүүгийн тайлангийн толгой хэсэгт дараах мэдээлэл орно. Үүнд:

- **байгууллагын нэр**
- санхүүгийн тайлан нь **бие даасан** аж ахуйн нэгжийнх үү эсвэл **булэг аж ахуйн нэгжийнх үү** гэдгийг заах
- толилуулж буй санхүүгийн тайлангийн **нэр**
- **тайлант хугацаа**
- тайлагналд ашигласан **мөнгөн тэмдэгт**
- цифрийн оронгийн **нарийвчлал** (мянган төгрөгөөр гм)

ТАЙЛБАР: Балансыг тодорхой нэг өдрийн байдлаар гаргадаг бөгөөд ихэвчлэн санхүүгийн жилийн сүүлийн өдрийн байдлаар бэлтгэдэг. Монгол улсад балансын өдөр нь 12-р сарын 31 юм.

Анхаарах зүйл:

БАЛАНС НЬ ТОДОРХОЙ ӨДРИЙН БАЙДЛААРХ БИЗНЕСИЙН ДҮР ЗУРАГ ЮМ

Балансад баримтлах гол зарчмууд нь:

- **Тасралтгүй үйл ажиллагааны зарчим**
- **Өртгийн зарчим**

СОЛОНГО КОМПАНИ БАЛАНС

1995 ОНЫ 12-Р САРЫН 31 (мянган төгрөгөөр)

ХӨРӨНГӨ

1995

1994

Эргэлтийн хөрөнгө

| | | |
|--|-----------------|----------------|
| Мөнгө | <u>3 943</u> | <u>7 922</u> |
| Дансны авлага | <u>156 749</u> | <u>82 839</u> |
| Бусад авлага | <u>3 763</u> | <u>4 718</u> |
| Ажилчдад олгосон урьдчилгаа | <u>5 009</u> | <u>42</u> |
| Хасах нь: Найдваргүй авлагын хасагдуулга | <u>(13 542)</u> | <u>-</u> |
| | <u>151 979</u> | <u>87 599</u> |
| Бараа материал | <u>409 639</u> | <u>433 070</u> |
| Бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн урьдчилгаа | <u>199 860</u> | <u>94 210</u> |
| Урьдчилж төлсөн зардал | <u>4 385</u> | <u>7 558</u> |
| | <u>769 806</u> | <u>630 359</u> |

Эргэлтийн хөрөнгийн дүн**Эргэлтийн бус хөрөнгө**

| | | |
|----------------------------------|------------------|-----------------|
| Барилга | <u>177 563</u> | <u>165 353</u> |
| Хасах нь: Хуримтлагдсан элэгдэл | <u>(15 360)</u> | <u>(13 916)</u> |
| | <u>162 203</u> | <u>151 437</u> |
| Дуусаагүй барилга - Зочид буудал | <u>5 645</u> | <u>5 172</u> |
| Дуусаагүй барилга – Үйлдвэр | <u>75 469</u> | <u>68 016</u> |
| | <u>243 317</u> | <u>224 625</u> |
| Хөрөнгө оруулалт | <u>1 600</u> | <u>1 600</u> |
| | <u>244 917</u> | <u>226 225</u> |
| | <u>1 014 723</u> | <u>856 584</u> |

ӨР ТӨЛБӨР

| | | |
|-------------------------------------|----------------|----------------|
| Дансны өглөг | <u>371 106</u> | <u>109 681</u> |
| Худалдан авагчдаас авсан урьдчилгаа | <u>14 623</u> | <u>18 708</u> |
| Засгийн газрын өглөг | <u>42 794</u> | <u>5 297</u> |
| Хүүгийн өглөг | <u>121 379</u> | <u>19 544</u> |
| ногдох хэсэг | <u>291 581</u> | <u>66 728</u> |
| Бусад богино хугацаат өглөг | <u>2 509</u> | <u>8 129</u> |

Богино хугацаат өглөгийн дүн

| | | |
|------------------------------|------------------|------------------|
| Урт хугацаат векселийн өглөг | <u>843 992</u> | <u>228 087</u> |
| | <u>982 440</u> | <u>986 126</u> |
| | <u>982 440</u> | <u>986 126</u> |
| | <u>1 826 432</u> | <u>1 214 213</u> |

ӨР ТӨЛБӨРИЙН НИЙТ ДҮН**ЭЗДИЙН ӨМЧ**

| | | |
|--|------------------|------------------|
| Энгийн хувьцаа (404,830 ширхэг, нэрлэсэн үнэ нь 100 төг) | <u>40 483</u> | <u>40 483</u> |
| Хуримтлагдсан ашиг | <u>(852 192)</u> | <u>(398 112)</u> |
| | <u>(811 709)</u> | <u>(357 629)</u> |
| | <u>1 014 723</u> | <u>856 584</u> |

Эздийн өмчийн дүн**ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН**

Орлогын тайлан

Орлогын тайланг зарим оронд үйл ажиллагааны тайлан гэж нэрлэдэг боловч энэ тайлан нь зөвхөн тухайн аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны орлого, зардлыг мэдээлээд зогсохгүй өөр өргөн мэдээллийг харуулдаг. Орлогын тайлан нь аж ахуйн нэгж, байгууллагын балансын нягтлан бодох бүртгэлийн хугацааны эхний болон эцсийн хугацааг хооронд нь холбож өгдөг. Аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн тайлангийн хэлбэр, бүрэлдэхүүн хэсгүүдийг толилуулах арга, нэмэлт мэдээлэлд хийх шаардлагатай тодруулгуудын талаар Санхүүгийн тайлан бэлтгэх болон толилуулах арга зүйд тусгасан (Сангийн яамны 1999 оны 215 тоот тушаалтыг хавсаргав).

Орлогын тайланда нягтлан бодох бүртгэлийн хоёр дахь үндсэн тэнцэтгэлийг ашигладаг:

Орлого - Зардал = Ашиг

Орлогын тайлангийн толгой хэсэгт балансынхтай адил мэдээлэл орно. Үүнд:

- **байгууллагын нэр**
- санхүүгийн тайлан нь **бие даасан** аж ахуйн нэгжийнх үү эсвэл **булэг аж ахуйн нэгжийнх үү** гэдгийг заах
- толилуулж буй санхүүгийн тайлангийн **нэр**
- **тайлант хугацаа**
- тайлагналд ашигласан **мөнгөн тэмдэгт**
- цифрийн оронгийн **хураангуйлалын** түвшин (мянган төгрөгөөр гм)

ТАЙЛБАР: Орлогын тайланг ихэвчлэн хуанлийн жилийн байдлаар бэлтгэдэг. Орлогын тайлангийн дуусгавар болох хугацаа нь балансын өдөртэй адил байна.

Анхаарах зүйл:

ОРЛОГЫН ТАЙЛАН НЬ ТОДОРХОЙ ХУГАЦААНД ЯВУУЛСАН БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ □ҮР ДҮНГ ХАРУУЛДАГ

Орлогын тайланда баримтлах гол зарчмууд нь:

- Цаг хугацаандaa байх
- Орлогын болон зохицох зарчим

Орлогын тайланда ашигладаг дээр харуулсан тэнцэтгэлийг энгийн хэлбэрээр харуулвал:

ОРЛОГО

**ХАСАХ НЬ ЗАРДАЛ
АШИГ (АЛДАГДАЛ)**

Энэ “Энгийн хэлбэр” нь үйлчилгээний байгууллагад ашиглахад тохиромжтой. Харин үйлдвэр болон жижиглэн худалдаа эрхэлдэг байгууллагын хувьд ерөнхий болон захиргааны зардлыг хасахын өмнөх борлуулалтын нийт орлого гэсэн хэлбэр илүү тохиромжтой.

Монгол улсад ашиглагдаж буй дэлгэрэнгүй хэлбэрийг харуулвал:

| | |
|----------------------|--|
| | ОРЛОГО |
| хасах нь | БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ӨРТӨГ |
| | НИЙТ АШИГ |
| хасах нь | <u>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ</u> |
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ (АЛДАГДАЛ) |
| нэмэх нь хасах нь | <u>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО</u> <u>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ</u> |
| | ЕРДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО |
| нэмэх нь хасах нь | ЕРДИЙН БУС АШИГ ЕРДИЙН БУС АЛДАГДАЛ |
| | ТАТВАРЫН ӨМНӨХ АШИГ |
| хасах нь | <u>ТАТВАРЫН ЗАРДАЛ</u> |
| | <u>ЦЭВЭР АШИГ (АЛДАГДАЛ)</u> |

Ердийн үйл
ажиллагаа

Ердийн бус үйл
ажиллагаа

СОЛОНГО КОМПАНИ

ОРЛОГЫН ТАЙЛАН
1995 ОНЫ 12-Р САРЫН 31
 мянган төгрөгөөр

| | 1995 | 1994 |
|--|------------------|------------------|
| ОРЛОГО | | |
| Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний борлуулалт | 866 812 | 1 033 530 |
| Худалдааны орлого | 196 352 | 337 460 |
| Цэвэр борлуулалт | 1 063 164 | 1 370 990 |
| Борлуулсан бэлэн бүтээгдэхүүний өртөг | 765 326 | 867 006 |
| Борлуулсан барааны өртөг | 180 899 | 327 671 |
| Нийт борлуулсан бүтээгдэхүүний өртөг | 946 225 | 1 194 677 |
| Нийт ашиг | 116 939 | 176 313 |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ | | |
| Борлуулалтын зардал | 9 033 | 5 155 |
| Захиргааны зардал | 43 255 | 28 979 |
| Ажиллагчдын хөнгөлөлт | 63 463 | 34 033 |
| Нийт үйл ажиллагааны зардал | 115 751 | 68 167 |
| Үйл ажиллагааны ашиг (алдагдал) | 1 188 | 108 146 |
| ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ | | |
| Хүүгийн зардал, цэвэр | 210 869 | 8 355 |
| Валютын ханшийн Өөрчлөлтийн алдагдал | 244 399 | 268 372 |
| | 455 268 | 276 727 |
| Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал) | (454 080) | (168 581) |
| Орлогын татварын зардал | - | - |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | (454 080) | (168 581) |

Өмчийн өөрчлөлтийн тайлан

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар байгууллагын тайлант хугацааны хуримтлагдсан ашигт гарсан өөрчлөлт, хөдөлгөөнийг харуулдаг. Энэ тайлан нь баланс болон орлогын тайлангийн хоорондын холбоос юм.

ТАЙЛБАР: Өмчийн өөрчлөлтийн тайлан нь Орлогын тайлангийн нэгэн адил тодорхой хугацааг хамаардаг бөгөөд энэ хугацаа нь Орлогын тайлангийн хугацаатай адил байна. Орлогын тайлангийн нэгэн адил энэ тайлангийн дуусгавар болох хугацаа нь балансын өдөртэй адил байна.

Дээр дурьдсан санхүүгийн тайлангийн ерөнхий хоёр зорилгын дагуу энэ санхүүгийн тайланд: **байгууллагын нэр**, санхүүгийн тайлан нь **бие даасан** аж ахуйн нэгжийнх үү эсвэл **булэг аж ахуйн нэгжийнх үү** гэдгийг зааж, толилуулж буй санхүүгийн тайлангийн **нэр**, **тайлант хугацаа**, тайлагнаад ашигласан **мөнгөн тэмдэгт, мянгачлалын түвшинг агуулна**.

Өмчийн өөрчлөлтийн тайланд дараах зүйлсийг харуулна. Үүнд:

- Тайлант хугацааны өмчийн өөрчлөлтийн эхний үлдэгдэл
- Тайлант хугацаанд гарсан өөрчлөлт, хөдөлгөөн
- Нягтлан бодох бүртгэлийн бодлогод оруулсан өөрчлөлт
- Дахин үнэлгээ
- Ханшийн хөрвүүлэлтийн зөрүү
- Орлогын тайланд тусгагдаагүй цэвэр ашиг, алдагдал
- Тайлант хугацааны цэвэр ашиг
- Ногдол ашиг
- Хувьцаа гаргалт
- Тайлант хугацааны өмчийн өөрчлөлтийн эцсийн үлдэгдэл

Цаашлаад өмчийн бүрэлдэхүүн хэсэг бүрт дараах мэдээллийг харуулна. Үүнд:

- * Хувьцаат капитал
- * Нэмж төлөгдсөн капитал
- * Дахин үнэлгээ
- * Хөрвүүлэлтийн зөрүү
- * Хуримтлагдсан ашиг

Монгол улсад өмчийн өөрчлөлтийн тайланг гаргаж буй хэлбэр нь НББОУС 1-ын хавсралтад үзүүлсэнтэй тохирч байна.

СОЛОНГО КОМПАНИ
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН
1995 ОНЫ 12 САРЫН 31
 (мянган төгрөгөөр)

| ЗҮЙЛ | Хувьцаат капитал | Хувьцааны урамшуулал | Дахин үнэлгээний нөөц | Хөрвүүлэх нөөц | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|---|---------------------|-------------------------|-----------------------------|-------------------|-----------------------|-----------|
| 1993 оны 12 сарын 31 ний үлдэгдэл | 40,483 | | | | (216,341) | (175,858) |
| Бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | | | |
| Залруулсан үлдэгдэл | | | | | | |
| Өмчийн дахин үнэлгээний нэмэгдэл | | | | | | |
| Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний буралт | | | | | | |
| Валютын хөрвүүлэлтийн нөөц | | | | | | |
| Орлогын тайланда хүлээн зөвшөөрөөгүй олз гарз | | | | | | |
| Тайлант үеийн цэвэр ашиг | | | | | (168,581) | (168,581) |
| Ноогдол ашиг | | | | | (13,190) | (13,190) |
| Гаргасан хувьцаат капитал | | | | | | |
| 1994 оны 12 сарын 31 ний үлдэгдэл | 40,483 | | | | (398,112) | (357,629) |
| Өмчийн дахин үнэлгээний бууралт | | | | | | |
| Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний нэмэгдэл | | | | | | |
| Валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | | | |
| Орлогын тайланда хүлээн зөвшөөрөөгүй олз гарз | | | | | | |
| Тайлант үеийн цэвэр ашиг | | | | | (454,080) | (454,080) |
| Ноогдол ашиг | | | | | | |
| Гаргасан хувьцаат капитал | | | | | | |
| 1995 оны 12 сарын 31 ний үлдэгдэл | 40,483 | | | | (852,192) | (811,709) |

Мөнгөн гүйлгээний тайлан

Мөнгөн гүйлгээний тайланда баланс болон орлогын тайланда тусгагдаагүй чухал мэдээлэл агуулагддаг. НББОУС нь аж ахуйн нэгж байгууллагын тайлагналыг хуримтлуулсан байдлаар харуулахыг шаарддаг. Иймээс орлого бодитоор ороогүй ч гэсэн орлогыг хуримтлуулан бүртгэж, зардлыг бодитоор төлөөгүй ч гэсэн мөн хуримтлуулан тооцно. Орлогын тайлан нь компанийн мөнгөн хөрөнгийн байдлыг санхүүгийн тайлан хэрэглэгчдэд харуулдаггүй бөгөөд харин балансад мөнгөн хөрөнгийг зөвхөн тодохой өдрийн байдлаар харуулдаг. Үйл ажиллагаа нь хурдацтай өргөжиж байгаа компанийн баланс, орлогын тайланда үйл ажиллагаа нь сайн харагдаж болох боловч үнэн хэрэгтээ компани дампуурах дэхсэн байж болно. Дампуурлын шинж тэмдэг нь өр төлбөрийн хэмжээ хөрөнгийн хэмжээнээс давах бөгөөд бас нэг шинж нь компани хүлээсэн үүргээ хугацаанд нь биелүүлж чадахгүй байхыг хэлнэ. Түргэн өсч буй компаниудын хувьд мөнгөн гүйлгээний бэрхшээлтэй асуудал байдаг нь гэнэтийн өсөлтийн үед орлогын мөнгөн гүйлгээнээс зарлагын мөнгөн гүйлгээ нь илүү байдаг. Иймээс санхүүгийн тайлангийн хэрэглэгчид мөнгөн гүйлгээний тайлантай танилцаж мэдээлэл авдаг. НББОУС-д мөнгөн гүйлгээний тайланг нарийвчлан тайлбарлаж, холбогдох жишээнүүдийг харуулсан байдаг.

Энэ тайлангийн зорилгоор доорхи нэр томёог дараахь утгаар ойлговол зохино:

- **Мөнгөн хөрөнгө** гэж гар дээрх мөнгө болон хугацаагүй хадгаламж юм.
- **Мөнгөтэй адилтгах хөрөнгө** гэж үнэ цэнийг өөрчлөх өчүүхэн бага эрсдлийг мэдэрдэг, тодорхой дүнтэй мөнгөнд чөлөөтэй шилждэг, хөрвөх чадвар сайтай богино хугацааны хөрөнгө оруулалт юм.
- **Мөнгөн гүйлгээ** гэж мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн дотогш ба гадагш чиглэсэн урсгал юм.

Мөнгөн гүйлгээний тайланда гурван төрлийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээг харуулдаг.

- **Үндсэн үйл ажиллагаа:** Бизнесийн ердийн үйл ажиллагааны туршид гүйцэтгэх үйл ажиллагааг хэлнэ. Энэ хэсэгт Орлогын тайлан болон Балансын орлогын тайлантай харьцдаг дансуудтай холбоотой үйл ажиллагаа багтана (жишээ нь: Дансны авлага, Бараа материал, Дансны өглөг, Хуримтлуулсан зардлын өглөг гм).
- **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа:** Урт хугацаат хөрөнгөнд оруулсан бизнесийн хөрөнгө оруулалттай холбоотой үйл ажиллагаа орно (жишээ нь: Газар, тоног төхөөрөмж, хөрөнгө оруулалтын зорилгоор эзэмшиж буй өөр компанийн хувьцаа, бондыг худалдаж авах гэх мэт)
- **Санхүүгийн үйл ажиллагаа:** Хөрөнгө оруулагчид болон зээлдэгчидтэй холбоотой үйл ажиллагаа орно (жишээ нь: богино болон урт хугацаат зээл, төлсөн ногдол ашиг, гаргасан хувьцаа гм).

Мөнгөн гүйлгээний тайлан нь аккруэл сууриар бүртгэгдсэн дүнг мөнгөн суурьт шилжүүлж харуулдаг.

НББОУС-д үйл ажиллагааны мөнгөн урсгалыг тодорхойлох хоёр арга байдаг.

Үүнд:

- **Шууд арга** –мөнгөөр хүлээж авсан болон мөнгөөр төлсөн дунг харуулахын тулд нягтлан бодох бүртгэл дэх мэдээллийг ашигладаг. НББОУС 7-д шууд аргыг санхүүгийн тайлан хэрэглэгчдэд хамгийн ашиг тустай арга гэж үзэж байна.
- **Шууд бус арга**– Цэвэр ашгийг мөнгөн бус ажил гүйлгээгээр (Орлогын тайлангийн) тохируулдаг арга. (Жишээ нь: элэгдэл хорогдлын зардлыг цэвэр ашгийн дүн дээр буцаан нэмж тохируулдаг нь энэ зүйлийг хассаны дараа цэвэр ашгийг гаргадагтай холбоотой). Монгол улсад мөнгөн гүйлгээний тайланг шууд бус аргад үндэслэн бэлтгэдэг.

Үндсэн үйл ажиллагааны хэсгийг шууд бус аргаар бэлтгэсэн мөнгөн гүйлгээний тайландаа ашиглах үед эргэлтийн хөрөнгө ба богино хугацаат өр төлбөрийн мөнгөн гүйлгээнд үзүүлсэн нөлөөг шууд таамаглахад хялбар биш. Иймээс хөрөнгө буурах болон өр төлбөрийн хэмжээ нэмэгдэхэд мөнгө орж ирдэг, харин хөрөнгө нэмэгдэх болон өр төлбөр багасахад мөнгө зарцуулагддаг гэдгийг санах нь чухал юм.

Холбогдох үндсэн дүрмүүд:

- Дараах тохиолдолд мөнгөн гүйлгээ нэмэгдэнэ:
 - Эргэлтийн хөрөнгө буурвал эсвэл
 - Богино хугацаат өр төлбөр нэмэгдвэл
- Дараах тохиолдолд мөнгөн гүйлгээ багасна:
 - Эргэлтийн хөрөнгө нэмэгдвэл эсвэл
 - Богино хугацаат өр төлбөр буурвал

Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээг бодоходоо цэвэр ашгаас эхэлдэг учраас цэвэр ашгийн дунд орсон хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд тохируулга хийдэг. Энэ тайлангийн хэлбэрт тохируулга хийх мөрүүд ордог.

**СОЛОНГО КОМПАНИ
МОНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН
1995 ОНЫ 12-Р САРЫН 31**

(мянган төгрөгөөр)

| ҮЗҮҮЛЭЛТ | 1995 | 1994 |
|--|------------------|------------------|
| Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
| Цэвэр орлого | (454 080) | (168 581) |
| Элэгдлийн зардал | 1 444 | 4 185 |
| Худалдсан үндсэн хөрөнгө, хөрөнгө оруулалтын | | |
| Алдагдал | | |
| Худалдсан үндсэн хөрөнгө, хөрөнгө оруулалтын ашиг | | |
| Авлага, бараа материал, урьдчилж төлсөн зардлын | | |
| нэмэгдэх өөрчлөлт | (170 985) | (60 950) |
| Авлага, бараа материал, урьдчилж төлсөн зардлын | | |
| хасагдах өөрчлөлт | 27 559 | |
| Богино хугацаат өглөг, урьдчилж орсон орлогын | | |
| нэмэгдэх өөрчлөлт | 400 757 | 53 492 |
| Богино хугацаат өглөг, урьдчилж орсон орлогын | | |
| хасагдах өөрчлөлт | <u>(9 705)</u> | <u>(19 261)</u> |
| Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ | <u>(205 010)</u> | <u>(191 115)</u> |
| Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны | | |
| мөнгөн гүйлгээ | | |
| Худалдсан үндсэн хөрөнгийн орлого | | |
| Худалдаж авсан үндсэн хөрөнгө | (20 136) | (181 040) |
| Худалдсан хөрөнгө оруулалтын орлого | | |
| Худалдаж авсан хөрөнгө оруулалт | | |
| Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ | <u>(20 136)</u> | <u>(181 040)</u> |
| Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
| Банкнаас авсан зээл | 224 853 | 358 241 |
| Улсаас өгсөн санхүүжилт | | |
| Төрөл бүрийн хандив | | |
| Зээлийн төлөлт | (3 686) | |
| Урт хугацаат өрийн тайлангийн хугацааны төлөлт | | |
| Гаргасан хувьцаа | | |
| Мөнгөөр эргүүлж худалдаж авсан хувьцаа | | |
| Ногдол ашгийг мөнгөөр төлсөн | | (13 190) |
| Санхүүгийн цэвэр мөнгөн гүйлгээ | <u>221 167</u> | <u>345 051</u> |
| БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | <u>(3 979)</u> | <u>(27 104)</u> |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | <u>7 922</u> | <u>35 026</u> |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | <u>3 943</u> | <u>7 922</u> |

ДАСГАЛ 2 - Мөнгөн гүйлгээний дасгал

Мөнгөн гүйлгээний тайлангийн аль хэсэгт дараах зүйлүүд орохыг тодорхойлохдоо хоосон зайнд тохиорох үгийг бичнэ үү.

Үйл ажиллагааг "Y" үсгээр, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг "X" үсгээр, санхүүгийн үйл ажиллагааг "C" үсгээр тус тус тэмдэглэнэ үү.

Түлхүүр: Эргэлтийн хөрөнгөтэй холбоотой ихэнх үйл ажиллагаа нь үндсэн үйл ажиллагаанд, эргэлтийн бус хөрөнгөтэй холбоотой ихэнх үйл ажиллагаа нь хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд хамрагдана. Харин урт хугацаат өр төлбөр болон эзэмшигчдийн өмчтэй холбогдон гарсан үйл ажиллагааг санхүүгийн үйл ажиллагаа гэж үздэг.

- | | |
|---|--|
| <input type="checkbox"/> хувьцааны борлуулалт | <input type="checkbox"/> үйлдвэрт ашиглагдаж буй тоног төхөөрөмжийн борлуулалт |
| <input type="checkbox"/> дансны авлагын өсөлт | <input type="checkbox"/> элэгдэл |
| <input type="checkbox"/> цэвэр ашиг | <input type="checkbox"/> ногдол ашиг төлөх |
| <input type="checkbox"/> 5 жилийн хугацаатай банкны зээл | <input type="checkbox"/> барилга худалдан авах |
| <input type="checkbox"/> тоног төхөөрөмж борлуулалтын олз | <input type="checkbox"/> хуримтлагдсан зардлын өглөгийн бууралт |

Нягтлан бodoх бүртгэлийн бодлого болон тайлбар тэмдэглэл

Аж ахуйн нэгж, байгууллага санхүүгийн тайлангийн тайлбар тэмдэглэлийг санхүүгийн тайлангийнхаа ард хавсаргах эсвэл хавсаргахгүй байхыг сонгох эрхгүй. Тайлбар тэмдэглэл нь санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг юм. НББОУС болон Монгол улсын СЭЗЯ-наас гаргасан заавар журамд шаардлагатай тодруулгуудын талаар дэлгэрэнгүй дурьдсан байдаг.

НББОУС 1-д зааснаар тайлбар тэмдэглэлд дараах мэдээллийг тусгадаг:

- Санхүүгийн тайланг бэлтгэсэн тайлагналын үндэс, суурийн талаарх мэдээлэл болон мөрдсөн нягтлан бodoх бүртгэлийн тусгай бодлогын талаар
- НББОУС-ын дагуу зохих тодруулгыг хийсэн байх
- Санхүүгийн тайланд тусгагдаагүй боловч үнэн зөв толилуулахад шаардлагатай нэмэлт мэдээлэл

Тайлбар тэмдэглэлийг дараах дэс дараалалтайгаар харуулдаг:

- Хэрэв НББОУС-ыг мөрдсөн бол энэ тухай дурьдана. **ТАЙЛБАР: Хэрэв Нягтлан бodoх бүртгэлийн холбогдох стандарт бүрийн бүх шаардлагыг болон Стандартын тайлбарын хорооны гаргасан шаардлагатай тайлбар бүрийг мөрдөөгүй бол санхүүгийн тайланд Нягтлан бodoх бүртгэлийн стандартад нийцсэн гэж дурьдах ёсгүй.**
- Аж ахуйн нэгж, байгууллагын мөрдсөн нягтлан бodoх бүртгэлийн бодлого болон ашигласан хэмжилт.
- Санхүүгийн тайланд толилуулсан үзүүлэлтүүдийг нотлох мэдээлэл (давхар шалгах).
- Бусад мэдээлэл.

Аж ахуйн нэгж, байгууллага тайлбар тэмдэглэлд мэдээллийг өөр өөрөөр харуулдаг боловч тайлбар тэмдэглэлийн зорилго нь санхүүгийн тайланд тусгагдсан эсвэл тусгагдаагүй мэдээллүүдээс санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд чухал гэсэн төрөл бүрийн мэдээллийн талаар дэлгэрэнгүй тайлбарлах явдал юм. Энэ мэдээллийг хүүрнэх хэлбэрээр бичдэг учраас санхүүгийн тайланг хэрэглэгчид нь санхүүгийн тайланд харуулсан тоон мэдээллийн талаарх ойлголтоо батжуулахад тусалдаг.

Сангийн сайдын 2000 оны 64 тоот тушаалаар баталсан **“Санхүүгийн тайлангийн тодруулга бэлтгэх үлгэрчилсэн заавар”** нь Монголын аж ахуйн нэгжүүд санхүүгийн тайландаа тодруулга хийх үндсэн асуудлуудыг тодорхойлсон байдаг.

Энэ зааварт зааснаар санхүүгийн тайлангийн тодруулгыг дараах дараалал, бүрэлдэхүүн хэсгийн байгуу хийж гүйцэтгэх ёстой:

1. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа ба зохион байгуулалт
2. Нягтлан бodoх бүртгэлийн бодлого
3. Санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулга

Нягтлан бodoх бүртгэлийн бодлого гэсэн хэсэгт нягтлан бodoх бүртгэлийн ерөнхий бодлогууд болон тусгай бодлогуудыг тус тусад нь тайлбарлаж тодруулна.

Үүнээс Санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулга гэдэг нь санхүүгийн тайлангийн үндсэн хэсгүүдийн нэмэлт тодруулгыг дараах үндсэн хүснэгтүүдээр бэлтгэж жилд нэгээс доошгүй удаа тайлагнах үйл ажиллагаа юм:

1. Мөнгөн хөрөнгө
2. Авлага

3. Бараа материал
4. Биет хөрөнгө
5. Биет бус хөрөнгө
6. Урт хугацаат хөрөнгө оруулалт ба авлага
7. Богино хугацаат өр төлбөр
8. Эздийн өмч
9. Орлого, зардал

Тодруулгын хүснэгтэн маягтыг байгууллага өөрийн үйл ажиллагааны онцлогт тохируулан өөрчлөн ашиглахыг энэ зааварт зөвшөөрсөн байна.

Европын компанийн 2000 оны санхүүгийн тайлангийн хөлийн тэмдэглэлийн жишээ.

Бараа материал

Бараа материалыг ЭАЭЗ аргыг ашиглан худалдан авалтын өртөг эсвэл үйлдвэрлэлийн өртгөөр үнэлсэн. Балансын дуусгавар өдрөөрх зах зээлийн доод үнэлгээтэй харьцуулахад бараа материалын үнэлгээ хэт өндөр байвал зохих түвшинтэй уялдуулан бууруулна. 2000 оны 12 сарын 31-ний өдрөөрх балансад цэвэр боломжит үнэ цэнийн хамгийн багаар тусгагдсан бараа материалын дүн 66 сая евротой тэнцүү байна (1999 онд: 60 сая евро байсан).

Бараа материалын дэлгэрэнгүй мэдээлэл:

| | 1999.12.31 | 2000.12.31 |
|---|------------|------------|
| Түүхий эд материал, хангамжийн материал | 464 | 544 |
| Дуусаагүй үйлдвэрлэл | 180 | 168 |
| Бэлэн бүтээгдэхүүн ба худалдах бараа | 861 | 999 |
| | 3535 | 3742 |

Худалдааны дансны авлага

Худалдааны дансны авлагатай холбоотой тусгай эрсдэлд зориулан найдваргүй авлагын хасагдуулга тооцдог. Компаний бодлогын дагуу 90 хоногоос дээш хугацаагаар цуглуулж чадаагүй дансны авлагад доод тал нь 50 хувийн хасагдуулга тооцдог. 180 хоногоос дээш хугацаагаар цуглуулаагүй авлагад 100 хувийн хасагдуулга тооцдог. 2000 онд найдваргүй авлагын хасагдуулга 24 сая евро байсан (1999 онд: 45 сая евро).

Биет үндсэн хөрөнгө

Биет үндсэн хөрөнгийг түүхэн өртгийн зарчмаар балансад тусгадаг. Элэгдлийг шулуун шугамын аргаар байгуулж, түүний анхны өртгийг ашиглагдах жилийн хугацаанд бууруулж бичсэнийг дор харуулав:

| | |
|--|-----------|
| Барилга байгууламж | 25-50 жил |
| Тоног төхөөрөмж | 10-15 жил |
| Тавилга, эд хогшил, мэдээллийн технологи | 3-8 жил |
| Автомашин | 5 жил |

Хөрөнгийн бууралт

Компани үндсэн хөрөнгийн дансны үнийг тооцоолсон хөнгөлөлттэй мөнгөн гүйлгээтэй харьцуулах замаар уг үндсэн хөрөнгийн үнэлгээний бууралтыг үечлэн шалгадаг. Хэрэв бууралтын алдагдал гарвал түүнийг уг тайлант хугацаанд хүлээн зөвшөөрдөг.

Болзошгүй хөрөнгө ба өр төлбөр

Компанийн эсрэг гарсан хуулийн зарга маргааны улмаас 290 сая европийн болзошгүй өр төлбөр компани төлөх байсан. Харин шүүх хурлын шийдвэрийн дагуу 150 сая европийн өр төлбөр хүлээх төлөвтэй байна.

Харин компанийд нааштайгаар шийдвэрлэх ойролцоогоор 190 сая европийн болзошгүй хөрөнгө бий болно.

Балансын дараах үйл явц

Хэрэв балансын дараах үйл явцын нөлөөгөөр балансын дуусгавар өдрөөрх хөрөнгө, өр төлбөрийн үнэлгээнд өөрчлөлт гарах нь илэрхий бол тохируулах бичилт хийнэ.

Холбогдох талын ажил гүйлгээ

Компани ойролцоогоор 26 сая европийн зээлийг удирдах ажилтнууддаа олгосон байна. Үүнээс зарим нь хүүгүй зээл бөгөөд үлдсэн нь 4.2- 7.2 хувийн хүүтэй зээл байна. 2000 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаарх зээлийн үлдэгдэл нь ойролцоогоор 12 сая европотой тэнцүү байна.

Солонго компанийн санхүүгийн иж бүрэн тайланг (Баланс, Орлогын тайлан, Мөнгөн гүйлгээний тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлан, Санхүүгийн тайлангийн тодруулгыг хамарсан) доор тусгайлан харууллаа.

СОЛОНГО КОМПАНИ

БАЛАНС

1995 ОНЫ 12-Р САРЫН 31 (мянган төгрөгөөр)

ХӨРӨНГӨ

1995

1994

Эргэлтийн хөрөнгө

| | | |
|--|------------------|------------------|
| Мөнгө | <u>3 943</u> | <u>7 922</u> |
| Дансны авлага | <u>156 749</u> | <u>82 839</u> |
| Бусад авлага | <u>3 763</u> | <u>4 718</u> |
| Ажилчдад олгосон урьдчилгаа | <u>5 009</u> | <u>42</u> |
| Хасах нь: Найдваргүй авлагын хасагдуулга | <u>(13 542)</u> | <u>-</u> |
| | <u>151 979</u> | <u>87 599</u> |
| Бараа материал(3) | <u>409 639</u> | <u>433 070</u> |
| Бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн урьдчилгаа | <u>199 860</u> | <u>94 210</u> |
| Урьдчилж төлсөн зардал | <u>4 385</u> | <u>7 558</u> |
| Эргэлтийн хөрөнгийн дүн | <u>769 806</u> | <u>630 359</u> |
| Эргэлтийн бус хөрөнгө | | |
| Барилга (6) | <u>177 563</u> | <u>165 353</u> |
| Хасах нь: Хуримтлагдсан элэгдэл | <u>(15 360)</u> | <u>(13 916)</u> |
| | <u>162 203</u> | <u>151 437</u> |
| Дуусаагүй барилга - Зочид буудал (4) | <u>5 645</u> | <u>5 172</u> |
| Дуусаагүй барилга – Үйлдвэр(4) | <u>75 469</u> | <u>68 016</u> |
| Биет хөрөнгийн дүн | <u>243 317</u> | <u>224 625</u> |
| Хөрөнгө оруулалт | <u>1 600</u> | <u>1 600</u> |
| Эргэлтийн бус хөрөнгийн дүн | <u>244 917</u> | <u>226 225</u> |
| НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | <u>1 014 723</u> | <u>856 584</u> |
| ӨР ТӨЛБӨР | | |
| Дансны өглөг | <u>371 106</u> | <u>109 681</u> |
| Худалдан авагчдаас авсан урьдчилгаа | <u>14 623</u> | <u>18 708</u> |
| Засгийн газрын өглөг | <u>42 794</u> | <u>5 297</u> |
| Хүүгийн өглөг | <u>121 379</u> | <u>19 544</u> |
| ногдох хэсэг | <u>291 581</u> | <u>66 728</u> |
| Бусад богино хугацаат өглөг | <u>2 509</u> | <u>8 129</u> |
| Богино хугацаат өглөгийн дүн | <u>843 992</u> | <u>228 087</u> |
| Урт хугацаат векселийн өглөг(6) | <u>982 440</u> | <u>986 126</u> |
| Урт хугацаат өглөгийн дүн | <u>982 440</u> | <u>986 126</u> |
| ӨР ТӨЛБӨРИЙН НИЙТ ДҮН | <u>1 826 432</u> | <u>1 214 213</u> |
| ЭЗДИЙН ӨМЧ | | |
| Энгийн хувьцаа (404,830 ширхэг, нэрлэсэн үнэ нь 100 төг) | <u>40 483</u> | <u>40 483</u> |
| Хуримтлагдсан ашиг | <u>(852 192)</u> | <u>(398 112)</u> |
| Эздийн өмчийн дүн | <u>(811 709)</u> | <u>(357 629)</u> |
| ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧИЙН ДҮН | <u>1 014 723</u> | <u>856 584</u> |

**СОЛОНГО КОМПАНИ
ОРЛОГЫН ТАЙЛАН
1995 ОНЫ 12-Р САРЫН 31**

мянган төгрөгөөр

| | 1995 | 1994 |
|--|------------------|------------------|
| ОРЛОГО | | |
| Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний борлуулалт | 866 812 | 1 033 530 |
| Худалдааны орлого | 196 352 | 337 460 |
| Цэвэр борлуулалт | <u>1 063 164</u> | <u>1 370 990</u> |
| Борлуулсан бэлэн бүтээгдэхүүний өртөг | 765 326 | 867 006 |
| Борлуулсан барааны өртөг | 180 899 | 327 671 |
| Нийт борлуулсан бүтээгдэхүүний өртөг | <u>946 225</u> | <u>1 194 677</u> |
| Нийт ашиг | 116 939 | 176 313 |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ | | |
| Борлуулалтын зардал | 9 033 | 5 155 |
| Захиргааны зардал | 43 255 | 28 979 |
| Ажиллагчдын хөнгөлөлт | <u>63 463</u> | <u>34 033</u> |
| Нийт үйл ажиллагааны зардал | <u>115 751</u> | <u>68 167</u> |
| Үйл ажиллагааны ашиг (алдагдал) | <u>1 188</u> | <u>108 146</u> |
| ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ | | |
| Хүүгийн зардал, цэвэр | 210 869 | 8 355 |
| Валютын ханшийн □өөрчлөлтийн алдагдал | <u>244 399</u> | <u>268 372</u> |
| Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал) | <u>455 268</u> | <u>276 727</u> |
| Орлогын татварын зардал | (454 080) | (168 581) |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | <u>-</u> | <u>-</u> |
| | <u>(454 080)</u> | <u>(168 581)</u> |

**СОЛОНГО КОМПАНИ
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН
1995 ОНЫ 12 САРЫН 31**

(мянган төгрөгөөр)

| ЗҮЙЛ | Хувьцаат капитал | Хувьцааны урамшуулал | Дахин үнэлгээний нөөц | Хөрвүүлэх нөөц | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|--|---------------------|-------------------------|-----------------------------|-------------------|-----------------------|-----------|
| 1993 оны 12 сарын 31 нийт үлдэгдэл | 40,483 | | | | (216,341) | (175,858) |
| Бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | | | |
| Залруулсан үлдэгдэл | | | | | | |
| Өмчийн дахин үнэлгээний нэмэгдэл | | | | | | |
| Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний буралт | | | | | | |
| Валютын хөрвүүлэлтийн нөөц | | | | | | |
| Орлогын тайландаа хүлээн зөвшөөрөөгүй олз гарз | | | | | | |
| Тайлант үеийн цэвэр ашиг | | | | | (168,581) | (168,581) |
| Ноогдол ашиг | | | | | (13,190) | (13,190) |
| Гаргасан хувьцаат капитал | | | | | | |
| 1994 оны 12 сарын 31 нийт үлдэгдэл | 40,483 | | | | (398,112) | (357,629) |
| Өмчийн дахин үнэлгээний бууралт | | | | | | |
| Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний нэмэгдэл | | | | | | |
| Валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | | | |
| Орлогын тайландаа хүлээн зөвшөөрөөгүй олз гарз | | | | | | |
| Тайлант үеийн цэвэр ашиг | | | | | (454,080) | (454,080) |
| Ноогдол ашиг | | | | | | |
| Гаргасан хувьцаат капитал | | | | | | |
| 1995 оны 12 сарын 31 нийт үлдэгдэл | 40,483 | | | | (852,192) | (811,709) |

**СОЛОНГО КОМПАНИ
МОНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН
1995 ОНЫ 12-Р САРЫН 31**

(мянган төгрөгөөр)

| ҮЗҮҮЛЭЛТ | 1995 | 1994 |
|--|------------------|------------------|
| Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
| Цэвэр орлого | (454 080) | (168 581) |
| Элэгдлийн зардал | 1 444 | 4 185 |
| Худалдсан үндсэн хөрөнгө, хөрөнгө оруулалтын | | |
| Алдагдал | | |
| Худалдсан үндсэн хөрөнгө, хөрөнгө оруулалтын ашиг | | |
| Авлага, бараа материал, урьдчилж төлсөн зардлын | | |
| нэмэгдэх өөрчлөлт | (170 985) | (60 950) |
| Авлага, бараа материал, урьдчилж төлсөн зардлын | | |
| хасагдах өөрчлөлт | 27 559 | |
| Богино хугацаат өглөг, урьдчилж орсон орлогын | | |
| нэмэгдэх өөрчлөлт | 400 757 | 53 492 |
| Богино хугацаат өглөг, урьдчилж орсон орлогын | | |
| хасагдах өөрчлөлт | <u>(9 705)</u> | <u>(19 261)</u> |
| Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ | <u>(205 010)</u> | <u>(191 115)</u> |
| Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны | | |
| мөнгөн гүйлгээ | | |
| Худалдсан үндсэн хөрөнгийн орлого | | |
| Худалдаж авсан үндсэн хөрөнгө | (20 136) | (181 040) |
| Худалдсан хөрөнгө оруулалтын орлого | | |
| Худалдаж авсан хөрөнгө оруулалт | | |
| Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ | <u>(20 136)</u> | <u>(181 040)</u> |
| Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
| Банкнаас авсан зээл | 224 853 | 358 241 |
| Улсаас өгсөн санхүүжилт | | |
| Төрөл бүрийн хандив | | |
| Зээлийн төлөлт | (3 686) | |
| Урт хугацаат өрийн тайлангийн хугацааны төлөлт | | |
| Гаргасан хувьцаа | | |
| Мөнгөөр эргүүлж худалдаж авсан хувьцаа | | |
| Ногдол ашгийг мөнгөөр төлсөн | | (13 190) |
| Санхүүгийн цэвэр мөнгөн гүйлгээ | <u>221 167</u> | <u>345 051</u> |
| БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | <u>(3 979)</u> | <u>(27 104)</u> |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | <u>7 922</u> | <u>35 026</u> |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | <u>3 943</u> | <u>7 922</u> |

**СОЛОНГО ҚОМПАНИ
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГУУДЫН ТЭМДЭГЛЭЛ
1995 ОНЫ 12-Р САРЫН 31**

Компани анх 1982 онд мебель тавилга Үйлдвэрлэх чиглэлээр байгуулагдсан бөгөөд өнөөгийн байдлаар үндсэн үйл ажиллагааныхаа зэрэгцээ мөн зарим төрлийн худалдааны үйл ажиллагаа явуулж байна.

1. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого

Санхүүгийн тайлангуудыг Олон Улсын Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартын дагуу бэлтгэсэн. Нягтлан Бодох Бүртгэлийн Үндсэн Бодлогыг дараах байдлаар нэгтгэн дүгнэж болно /мянган төгрөгөөр/.

/а/ Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгагчид

Мөнгөн хөрөнгө нь гар дээр болон банк, санхүүгийн байгууллагад байрлуулж буй анхны шаардлагаар зарцуулах боломжтой мөнгөн хөрөнгийг илэрхийлнэ.

/б/ Дансны авлага

Компани бүтээгдэхүүнээ агуулахаас ачуулсан даруй борлуулалт болон мөн холбогдох авлагыгг бүртгэлд тусгаж байна. Мөн бараа бүтээгдэхүүнийг ачуулахаас өмнө үйлчлүүлэгч, худалдан авагчид урьдчилсан мөнгөн төлбөр хийсэн байх тохиолдол олонтаа ажиглагддаг. Энэхүү урьдчилгааг худалдан авагчаас хүлээн авсан урьдчилгаа буюу урьдчилж орсон орлого богино хугацаат өр төлбөрийн хэсэгт илэрхийлнэ. Үүнтэй адилаар компани зарим төрлийн түүхий эд материал худалдан авахдаа урьдчилсан төлбөр хийдэг. Энэ урьдчилгааг бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн урьдчилгаа гэж харуулах ба эргэлтийн хөрөнгийн хэсэгт илэрхийлнэ.

/в/ Бараа материал

Бараа материалыг жинэлсэн дундаж өртгийн аргыг ашиглан тооцоолсон өртөг болоод цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар нь үнэлж илэрхийлсэн. Дуусаагүй Үйлдвэрлэл болон бэлэн бүтээгдэхүүний өртөг нь шууд материал, шууд хөдөлмөр болон шууд холбогдолтой үйлдвэрлэлийн бусад /нэмэгдэл/ зардлаас бүрдэнэ. Шаардлагатай тохиолдолд хуучирсан, удаан эргэлттэй, гологдол бүтээгдэхүүний хувьд үнийн бууралт тооцсон. Цэвэр боломжит үнэ цэнэ нь бараа бүтээгдэхүүнийг дуусгавар болгох болон худалдан борлуулахтай холбогдсон маркетинг, борлуулалтын зардлыг хассан борлуулалтын үнэтэй тэнцүү байна.

/г/ Хөрөнгө оруулалт

Компани урт хугацаат хөрөнгө оруулалтаа цэвэр боломжит үнэ цэнээс нь доогуур өртгөөр илэрхийлдэг. Хөрөнгө оруулалт нь бусад хувьцаат компанийн хувьцаанд хийсэн хөрөнгө оруулалт юм. Урт хугацаат хөрөнгө оруулалтын үнэ цэнэд байнгын шинж чанартай бууралт гарсан тохиолдолд энэхүү үнэ цэнийн уналтыг гарсан үед нь бүртгэлд тусгана.

/д/ Орлогын хүлээн зөвшөөрөлт

Орлого нь худалдан борлуулсан бараа бүтээгдэхүүний холбогдох буцаалт болон үнийн бууралтыг хассан худалдан авагчаас нэхэмжилсэн үнийн цэвэр дүнг илэрхийлэх бөгөөд бараа бүтээгдэхүүнийг ачуулж түүнийг өмчлөх эрх нь худалдан авагчид шилжсэн үед хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

/е/ Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийг нь хассан өртгөөр илэрхийлнэ. Капиталжуулсан сэлбэг хэрэгслийг тоног төхөөрөмжийн өртөгт оруулан холбогдох үндсэн хөрөнгийн нэгэн адил түвшнээр элэгдүүлнэ. Элэгдлийг засгийн газраас тогтоосон шулуун шугамын аргаар байгуулах бөгөөд зарим тохиолдолд хөрөнгийн ашиглагдах хугацааны явцад өртийг нь багасгаж болно. Жилийн элэгдлийн түвшин дараах хэлбэртэй байна. Үүнд:

| | |
|--------------------|---------|
| Газар | Байхгүй |
| Барилга байгууламж | 1.2% |
| Тоног төхөөрөмж | 9.0% |
| Тавилга, эд хогшил | 8.33% |
| Тээврийн хэрэгсэл | 12.5% |

/ж/ Гадаад валютын гүйлгээ

Компани данс бүртгэлээ Монгол төгрөгөөр бүртгэдэг бөгөөд гадаад валютаар хийгдсэн ажил гүйлгээг гарсан үед нь тухайн үеийн валютын ханшаар бодож тооцно. Балансын тасалбар болох хугацааны албан ёсны валютын ханшийг ашиглан гадаад валютаарх хөрөнгө, өр төлбөрийг монгол төгрөгөөр илэрхийлдэг. Ханшийн зөрүүтэй холбогдсон бүхий л ашиг, алдагдлыг тухайн тайлант хугацаанд Орлогын тайландаа бүртгэнэ.

/з/ Орлогын албан татвар

Орлогын албан татварын хуульд заасан хувь хэмжээгээр тухайн компани нь орлогын албан татвараа төлнө. Санхүүгийн тайлагналын зорилгоор орлого, зардлыг хүлээн зөвшөөрч бүртгэх болон орлогын татвар тооцох зорилгоор орлого, зардлыг хүлээн зөвшөөрч бүртгэх зэргийн хооронд ямар нэгэн цаг хугацааны түр ялгаа үүсдэггүй ажээ.

2. Ажилчин, албан хаагчдад олгосон урьдчилгаа

1993 оноос компани ажилчиддаа зориулж орон сууц захиалан бариулж байна. Барилгын нийт өртөг 87,315 төгрөг юм. Уг үнийн дүнгийн 60 хувийг компани, үлдсэнийг нь орон сууц худалдан авагч тухайн ажилчин албан хаагч хариуцан төлнө. 1995 оны 12-р сарын 31-ний байдлаар ажилчин албан хаагчид үүнтэй холбоотойгоор 4,800 мянган төгрөгний өртэй байсан ба уг үзүүлэлтийг ажилчин, албан хаагчдад олгосон урьдчилгаа гэсэн хэсэгт хамруулсан болно. Холбогдох хөнгөлөлтийг Орлогын тайландаа ажилчин, албан хаагчдад олгосон хөнгөлөлт гэсэн нэрийн дор илэрхийлсэн болно.

1994 онд компани мөн ажилчиддаа худалдах зорилгоор өөр барилга захиалан бариулах болсон. Уг барилгын нийт өртөг нь 219,000 мянган төгрөг байна. Компани нийт үнийн дүнгээс 60 хувийг төлөх ба харин ажилчид үлдсэн 40 хувийг нь төлөх ёстой ажээ. 1995 оны 12 сарын 31-ний байдлаар компани 79,474 мөнгөн төгрөгийг төлсөн бөгөөд үүнийг ажилчин албан хаагчдад олгосон урьдчилгаа гэсэн хэсэгт хамруулан илэрхийлсэн. Барилгын компани 139,526 мянган төгрөгний үлдэгдлийг хараахан нэхэмжлээгүй байгаа бөгөөд энэ дүн нь компанийн данс бүртгэлд тусгагдаагүй ажээ. Компанийн хувьд энэхүү үлдэгдэл нь болзошгүй өр төлбөр юм. Ажилчдын төлбөл зохих нийт 87,600 мянган төгрөгөөс 1995 оны 12-р сарын 31-ний байдлаар компани 18,598 төгрөгийг хүлээн аваад байсан ба уг хэмжээг өглөгийн дансанд оруулсан. Ажиллагчидтай холбогдох 131,400 мянган төгрөгийн хөнгөлөлтийг орон сууц барих ажил дуусгавар болох хүртэл ажиллагчдын хөнгөлөлт гэж бүртгээгүй.

3. Барилга материал

Бараа материалд түүхий эд, материал, дуусаагүй үйлдвэрлэл ба бэлэн бүтээгдэхүүн, худалдах зориулалт бүхий бараа, сэлбэг хэрэгсэл /капитал сэлбэгийг үндсэн хөрөнгийн өртөгт оруулна/ орно. 12-р сарын 31-ний байдлаар бараа материалын хэсэг дараах бүрэлдэхүүнтэй байжээ. Үүнд:

| | <u>1995</u> | <u>1994</u> |
|--|----------------|----------------|
| Түүхий эд материал | 169,678 | 165,942 |
| Сав баглаа боодол ба хангамжийн материал | 23,826 | 22,601 |
| Дуусаагүй үйлдвэрлэл | 77,446 | 90,191 |
| Бэлэн бүтээгдэхүүн | 18,808 | 5,488 |
| Худалдах бараа | 11,140 | 22,464 |
| Сэлбэг хэрэгсэл | <u>113,701</u> | <u>121,433</u> |
| | <u>409,639</u> | <u>433,070</u> |

4. Дуусаагүй барилга

Компани гэрээний үндсэн дээр өөрийн бизнеийн үйл ажиллагаанд ашиглагдах үйлдвэр, мөн эргүүлж худалдах зорилгоор зочид буудал зэргийг тус тус бариулж байна. 1995 оны 12-р сарын 31-ний байдлаар барилгын хоёр төсөл дээрх ажил бүгд зогсонги байдалд орсон. Хоёр барилгын нийт гэрээт үнэ 200,000 мянган төгрөг бөгөөд компани хийсэн хөрөнгө оруулалтаа нөхөх эсэх нь тодорхой бус байна. Мөн компани гэрээнд заасан ёсоор нэмэлт төлбөр хийж болох эсэх талаар тодорхой бус байна.

5. Үндсэн хөрөнгө

12-р сарын 31-ний байдлаарх үндсэн хөрөнгө нь дараах бүтэцтэй байна. Үүнд:

| | <u>1995</u> | <u>1994</u> |
|---------------------------------|-----------------|-----------------|
| Байгууламж | 22,749 | 2,749 |
| Барилга | 9,330 | 9,330 |
| Тоног төхөөрөмж | 23,826 | 2,601 |
| Тээврийн хэрэгсэл | 77,446 | 0,191 |
| Конторын тоног төхөөрөмж | 26,843 | 21,965 |
| Бусад | <u>4,009</u> | <u>3,759</u> |
| | <u>177,563</u> | <u>165,353</u> |
| Хасах нь: Хуримтлагдсан элэгдэл | <u>(15,360)</u> | <u>(13,916)</u> |
| | <u>162,203</u> | <u>151,437</u> |

6. Урт хугацаат өр

1993 ба 1994 онуудад компани гадаадын компаниудтай гэрээ байгуулан нийт 22,223,000 Австри шиллинг, 613,000 Герман маркийн зээл тус тус авсан ажээ. Эдгээр зээлийн хүү нь харгалзан 5.25 ба 3 хувь юм. Зээлийн үндсэн өрийн хэмжээ болоод хүүгийн төлбөрийг улирал тутам гүйцэтгэх бөгөөд эцсийн төлбөрийг 2003 ба 2002 онд тус тус гүйцэтгэх ажээ. Зээлийн баталгаанд компани тоног төхөөрөмжөө барьцаалсан байна.

B. АККРУЭЛ СУУРЬТАЙ НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ

Орлого, зардалтай холбоотой ажил гүйлгээг бүртгэх хамгийн хялбар арга бол мөнгө хүлээн авсан үед орлогыг, мөнгө төлсөн үед зардлыг бүртгэх юм. Үүнийг мөнгөн суурьтай НББ гэж нэрлэдэг. Ажил гүйлгээг мөнгөн сууриар бүртгэхэд стандартын үзэл баримтлалд заасан НББ-ийн үндсэн зарчмуудыг зөрчихөд хүрдэг. Ялангуяа:

Орлогын зарчим
Зохицох зарчим

НББОУС болон Монгол улсад мөрдөж байгаа НББ-ийн заавар аргачлалд аккруэл сууриар ажил гүйлгээг бүртгэхийг шаарддаг.

Аккруэл суурьт НББ: Орлогыг олсон үед нь бүртгэнэ.
 Зардлыг гарсан үед нь бүртгэнэ.

Аккруэл суурьтай НББ-ийг ойлгох хамгийн хялбар арга бол түүнийг мөнгөн суурьтай НББ-тэй харьцуулж үзэх явдал юм.

Гол ялгаа нь үйл ажиллагааг **хэзээ** бүртгэх вэ гэдэгт оршиж байна:

| | |
|----------------------------|-----------------------------|
| <u>Мөнгөн суурь</u> | <u>Аккруэл суурь</u> |
|----------------------------|-----------------------------|

| | | |
|--------|-------------------------|-------------------------|
| Орлого | ХҮЛЭЭЖ авсан үед | ОРЛОГО олсон үед |
| Зардал | ТӨЛСӨН үед | ГАРСАН үед |

- А компани Б компанид 2 сая төгрөгийн хөлс бүхий үйлчилгээ үзүүлсэн. Бүх үйлчилгээг 2000 оны 12-р сард үзүүлж дууссан боловч Б компани 2001 оны 1-р сар хүртэл үйлчилгээний хөлсөө төлөөгүй. Аккруэл суурийг мөрддөг бол А компани энэ орлогоо 2000 онд бүртгэх үү, 2001 онд бүртгэх үү?
- Б компани А компаниас 2000 оны 12-р сард зөвлөгөө өгсөн үйлчилгээний нэхэмжлэх хүлээн авсан. Уг нэхэмжлэх 2001 оны 3-р сард төлөгдсөн. Тэгвэл Б компани энэ зардлыг 2000, 2001 оны алинд нь бүртгэх вэ?
- Х компани 2000 оны 11-р сарын телефон үйлчилгээний хураамжийн нэхэмжлэхийг 2000 оны 12-р сард хүлээж аваад 2001 онд түүнийг төлжээ. Аккруэл суурийг баримталбал телефоны зардлыг хэзээ бүртгэх ёстой вэ? Энэ зардлыг 2001 онд бүртгэх ёстой юу?

Дасгал 3- Мөнгөн болон аккруэл суурьтай НББ

Криатив компьютер консалтинг (KKK) компани 15,000,000 төгрөгийн үйлчилгээ үзүүлсэн. Үйлчилгээ үзүүлсэн бүх үйлчлүүлэгчдэд нэхэмжлэх явуулсан бөгөөд жилийн эцэст үүнээс дөнгөж 10,000,000 нь төлөгдсөн. Тухайн жилд KKK өөрийн ажиллагсдын цалин, давхар гэрээлэгчдэд 6,000,000 төгрөг төлсөн бөгөөд жилийн эцэст мөн 1,000,000-ийг нэмж төлнө. Бусад шууд зардал нь 1,000,000 үүнээс жилийн эцэст 500,000 төлөгдөөгүй байсан. Борлуулалтын зардал 1,200,000 төгрөг. Үүнээс 900,000-ийг жилийн эцэст төлсөн. Захиргаа, удирдлагын зардал 2,500,000, үүнийг бүгдийг нь төлсөн. Энэ зардалд дараа жилийн түрээсийн төлбөр болох 500,000 төгрөг орсон.

Мөнгөн сууриар тооцвол KKK-ийн ашиг ямар байх вэ? Аккруэлээр бүртгэсэн тохиолдолд энэ нь хэд болох вэ?

| | Мөнгө | Аккруэл |
|-------------------------------------|-------|---------|
| Борлуулалт | | |
| Борлуулалтын өртөг: Хөдөлмөр | | |
| Бусад шууд зардал | | |
| Нийт ашиг | | |
| Борлуулалтын зардал | | |
| Захиргааны зардал | | |
| Үйл ажиллагааны цэвэр орлого | | |

Мөнгөн суурьтай НББ-д авлага, өглөг гэсэн дансдыг ашигладаггүй. Үүнээс гадна мөнгөн ба аккруэл суурьт ННБ-ийн хооронд цаг хугацааны 4 гол ялгаа байдаг: Үүнийг жишээгээр хэрхэн тайлбарлах вэ?

- Урьдчилж төлсөн зардал**—Урьдчилж төлсөн боловч одоогоор гараагүй байгаа зардал.
- Хуримтлагдсан зардал**—Тайлант хугацааны эцэст гарсан, хараахан төлөгдөөгүй байгаа зардал.
- Урьдчилж орсон орлого**—Борлуулсан бараа, үзүүлсэн үйлчилгээнийхээ төлөө урьдчилж авсан төлбөр.
- Хуримтлагдсан орлого**—Тайлангийн хугацааны эцэст олсон боловч хараахан хүлээж аваагүй буюу бүртгээгүй байгаа орлого.

Жич: Урьдчилж төлсөн зардал ба Хуримтлагдсан орлого нь хөрөнгө (эргэлтийн); Хуримтлагдсан зардал ба Урьдчилж орсон орлого нь өр төлбөр (богино хугацаат) болно.

Зохицох зарчмыг санаж байна уу—Орлого ба зардал нь хоорондоо зохицож байх ёстой. Орлого олохын тулд гаргаж байгаа зардлыг уг орлогоо хүлээн зөвшөөрсөн тайлант хугацааны зардал гэж хүлээн зөвшөөрөх ёстой. Орлого, зардлын хоорондхи уялдаа холбоог нарийн тодорхойлоход хэцүү байвал зардлыг хэд хэдэн тайлант хугацааны туршид системтэй, жигд байдлаар хуваарилах ёстой.

ДАСГАЛ 4 - АККРУЭЛ НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ

1. Клийн виндоус түдэй компани өөрийн үйлчлүүлэгч зочид буудлын цонх угаах үйлчилгээг 1999 оны 12-р сарын 15-нд үзүүлжээ. 12-р сарын 16-нд уг үйлчилгээний хөлс болох 1,000,000 төгрөгийн нэхэмжлэхийг зочид буудал руу явуулсан. Зочид буудал нэхэмжлэхийг 2000 оны 1-р сарын 10-нд төлжээ. Бичилтийг Клийн компани 12-р сард хийсэн.

Хэрэв компани нэхэмжлэх явуулаагүй бол ямар бичилт хийх вэ??

Төлбөр хүлээн авсан 1-р сарын бичилтийг бүртгэ.

2. Бийг компани нэлээн том kontорын барилгатай. Энэ компани 2000 оны 3-р сарын 1-ээс хэсэг өмгөөлөгчдөд ажлын байр түрээслүүлсэн. Түрээсийн төлбөр сард 800,000 төгрөг бөгөөд 3 сар болгоны эцэст төлөхөөр гэрээ байгуулжээ. Эхний төлбөрийг 5-р сарын 31-нд, дараагийн төлбөрийг мөн гэрээнд заасны дагуу хийсэн. 2000 онд Бийг компани түрээсийн орлогоо хэдээр бүртгэх вэ? 2000 оны 12-р сарын 31-нд ямар бичилт хийх ёстой вэ?

2001 оны 2-р сарын 28-нд төлбөр хүлээн авах үед ямар бичилт хийх вэ?

3. 2001 оны 12-р сарын 25-нд А компани 180,000 төгрөгийн телефон үйлчилгээний нэхэмжлэх хүлээн авсан. Уг нэхэмжлэхийг 1-р сард төлнө. Тэгвэл А компани энэ төлбөрийг 2001 онд хэрхэн бүртгэх вэ?

Хэрэв нэхэмжлэх хүлээн аваагүй бол ямар бичилт хийх вэ?

1-р сард төлөх төлбөрийг хэрхэн бүртгэх вэ?

4. К компани ажиллагсдын цалинг 7 хоног бүрийн Баасан гарагт тавьдаг. Өдөр тутмын цалингийн зардал 100,000 төгрөг. Хэрэв НББ-ийн хугацаа (тайлант) Лхагва гарагт дуусгавар болдог гэж үзвэл К компани ямар бичилт хийх вэ? (7 хоногийн ажлын өдөр 5 бөгөөд Даваа гарагт эхэлдэг).

Цалин тавьж олгох өдөр ямар бичилт хийх вэ?

5. 2000 оны 11-р сарын 1-нд Фаст деливэри сервис компани ачааны машин худалдаж аваад 1 жилийн хугацаагаар даатгуулж, даатгалын төлбөрийг хийжээ. Үүний нийт өртөг нь 5,000,000 төгрөг болсон. Энэ ажил гүйлгээг яаж бүртгэх вэ?

12-р сарын 31-нд аль бичилт (хэрэв гарвал)-ийг бүртгэлд тусгах вэ?

6. Эурика майнинг компанийн 2002 оны жилийн эцсийн тайланд аудит хийнэ. Энэ үйлчилгээний хөлс 12,000,000 төгрөг болох тооцоо гарчээ. Үйлчилгээний хөлсийг аудит бүрэн хийж дууссаны дараа төлнө. Аудитын ихэнх ажил 2003 онд хийгдэх бол 2002 онд үүнийг хэрхэн бүртгэх вэ?
7. 2001 оны 7-р сарын 1-нд MWH сюпер консалтинг компани 1,000,000 төгрөгийн үнэ бүхий компьютер худалдан авч, төлбөрийг бэлнээр хийжээ. Ашиглахаар тооцсон хугацаа нь 5 жил, үлдэх өртөг байхгүй. Энэ худалдан авалтыг 2001 онд хэрхэн бүртгэх вэ?

Системтэй, жигд байх суурийг ашиглан компьютерийн зардлыг хэрхэн хуваарилах вэ?

2001 оны 12-р сарын 31-нд ямар бичилт хийх вэ? Мөн 2002 оны 12-р сарын 31-ээрх бичилтийг харуул.

8. Монголиан адванчэр тур компани 11-р сарын 1-нд 2,000,000 төгрөгийг 3 сарын хугацаатай хадгалуулсан. Хүү нь сарын 1%. Сар бүрийн эцэст ямар бичилт хийгдэх вэ?

Хэрэв 2-р сарын 28-нд хадгалуулсан мөнгөө буцаан татаж, хүүгээ хүлээн авсан бол ямар бичилт гарах вэ?

Г. ДАСГАЛЫН ХАРИУ

ДАСГАЛ 1 □ НББ-ийн зарчмууд

- 1 е , а Жижиг мөнгөн сангаас хийгдэх бүх төлбөрийг Бусад зардлын Дт-д бичнэ.
- 2 в,г,е Балансын огноо өдөр компанийн санхүүгийн тайланд албан ёсоор өр төлбөр гэж бүртгэгдээгүй боловч уг компанийн холбоотой шүүхийн шийдвэрээр үүсч болзошгүй өр төлбөрийн талаарх тайлбарыг санхүүгиний тайланд оруулдаг
- 3 д, г Урт хугацаат хөрөнгө оруулалтыг түүхэн өргөөр бүртгэнэ.
- 4 е Жижиглэнгийн дэлгүүр сар бүрийн санхүүгийн тайлан гаргах зорилгоор бараа материалын бүрэн тооллогоос өөр тооцоолол ашигладаг.
- 5 г, д Бараа материалыг өртөг зах зээлийн аль багаар буюу цэвэр боломжит үнэ цэнээр бүртгэнэ.
- 6 б 2000 ба 2001 онд бараа материалын бүртгэлийн адил арга ашиглана
- 7 е Томоохон үйлдвэрлэгч компанийд ашиглагддаг үнэ цэнэ багатай сэлбэг хэрэгслийг худалдан авах үед нь зардал гэж бүртгэдэг.

ДАСГАЛ 2 – Мөнгөн гүйлгээний тайлан

- | | |
|---|--|
| <u>C</u> хувьцааны борлуулалт | <u>X</u> үйлдвэрт ашиглагдаж буй тоног төхөөрөмжийн борлуулалт |
| <u>Y</u> дансны авлагын өсөлт | <u>Y</u> элэгдэл |
| <u>Y</u> цэвэр ашиг | <u>C</u> ногдол ашиг төлөх |
| <u>C</u> 5 жилийн хугацаатай банкны зээл | <u>X</u> барилга худалдан авах |
| <u>Y</u> тоног төхөөрөмж борлуулалтын олз | <u>Y</u> хуримтлагдсан зардлын өглөгийн бууралт |

ДАСГАЛ 3 - Мөнгө ба аккруэл суурьтай НББ

| | Мөнгө | Акрюль |
|-------------------------------------|------------------|------------------|
| Борлуулалт | 10,000,000 | 15,000,000 |
| Борлуулалтын өртөг: Хөдөлмөр | 6,000,000 | 7,000,000 |
| Бусад шууд зардал | <u>500,000</u> | <u>1,000,000</u> |
| Нийт ашиг | 3,500,000 | 7,000,000 |
| Борлуулалтын зардал | 900,000 | 1,200,000 |
| Захиргааны зардал | <u>2,500,000</u> | <u>2,000,000</u> |
| Үйл ажиллагааны цэвэр орлого | 100,000 | 3,800,000 |

ДАСГАЛ 4 – Аккруэл суурьтай бүртгэл**Хариу 1**

| | | | | |
|-------|----|---------------------|-----------|-----------|
| 1. а. | Дт | Дансны авлага | 1,000,000 | |
| | Кт | Борлуулалтын орлого | | 1,000,000 |

1.6 Бусад эргэлтийнхөрөнгийг Дт-лэнэ. (Хуримтлагдсан орлогын авлага)

| | | | | |
|-----|----|-------------------------|-----------|-----------|
| 1.в | Дт | Мөнгө | 1,000,000 | |
| | Кт | Дансны авлага | | 1,000,000 |
| | | Бусад эргэлтийн хөрөнгө | | |

Хариу 2

2.а 800,000 X 10 сар = 8,000,000

| | | | |
|----|-------------------------|---------|---------|
| Дт | Бусад эргэлтийн хөрөнгө | 800,000 | |
| | (Хуримтлагдсан орлого) | | |
| Кт | Борлуулалтын орлого | | 800,000 |

| | | | | |
|-----|----|-------------------------|-----------|-----------|
| 2.б | Дт | Мөнгө | 2,400,000 | |
| | Кт | Борлуулалтын орлого | | 1,600,000 |
| | Кт | Бусад эргэлтийн хөрөнгө | | 800,000 |

Хариу 3

3.а Дт Холбооны зардал 180,000

| | | |
|-----|-----------------|---------------------------------------|
| | Кт Дансны өглөг | 180,000 |
| 3.6 | Кт Бусад БХӨТ | 180,000 (Хуримтлагдсан зардлын өглөг) |
| 3.в | Дт Дансны өглөг | 180,000 |

Кт Бусад БХӨТ-Хуримтлагдсан зардлыг өглөг
Кт Мөнгө 180,000

Хариу 4

| | | |
|-----|----------------------------------|---------|
| 4.1 | Дт Цалингийн зардал | 300,000 |
| | Кт Бусад БХӨТ | |
| | буюу Хуримтлагдсан зардлын өглөг | 300,000 |
| 4.2 | Дт Цалингийн зардал | 200,000 |
| | Дт Бусад БХӨТ буюу хуримтлагдсан | |
| | зардлын өглөг | 300,000 |
| | Кт мөнгө | 500,000 |

Хариу 5

| | | |
|------|----------------------------|-----------|
| 5.1 | Дт Даатгалын зардал | 5,000,000 |
| буюу | Дт Урьдчилж төлсөн даатгал | 5,000,000 |
| | Кт Мөнгө | 5,000,000 |

Гэхдээ үүнийг яаж бүртгэх нь компанийн бодлогоос шалтгаална.

| | | |
|-------|----------------------------|-----------|
| 5.2 | Дт Урьдчилж төлсөн даатгал | 4,166,667 |
| | Кт Даатгалын зардал | 4,166,667 |
| ЭСВЭЛ | | |
| | Дт.Даатгалын зардал | 833,333 |
| | Кт Урьдчилж төлсөн даатгал | 33,333 |

Хариу 6

Харгалзаж үзэх янз бүрийн арга байгааг анхааран энэ асуултыг бүртгэх болсон шалтгааныг хэлэлцэх сэдэв болгон ашигла. Зардлыг хэзээ хүлээн зөвшөөрөхийг Удирдамж буюу НББОУС-ЫН дагуу тодорхойл. Тууштай байх зарчмыг анхаар.

Хариу 7

| | | |
|-----|-------------------|-----------|
| 7.1 | Дт Үндсэн хөрөнгө | 1,000,000 |
| | Кт Мөнгө | 1,000,000 |

7.2 Компьютерийг шулуун шугамын арга ашиглан 5 жилийн хугацаанд элэгдүүлнэ— $1,000,000 / 5 = 200,000$ (нэг жилийн элэгдлийн хэмжээ).

| | | |
|-----|--------------------------|---------|
| 7.3 | Дт Элэгдлийн зардал | 100,000 |
| | Кт Хуримтлагдсан элэгдэл | 100,000 |

2002 онд:

| | |
|--------------------------|---------|
| Дт Элэгдлийн зардал | 200,000 |
| Кт Хуримтлагдсан элэгдэл | 200,000 |

Хариу 8

| | | |
|-----|-------------------|--------|
| 8.1 | Дт Хүүгийн авлага | 20,000 |
| | Кт Хүүгийн орлого | 20,000 |
| 8.2 | Дт Мөнгө | 60,000 |
| | Кт Хүүгийн авлага | 60,000 |

Тухайн компани хүүг 1-р сарын 31-ээр хуримтлуулан бүртгэх эсэхээс хамааран энэ бичилт өөр байж болно.